



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 04 он 03
сарын 19 өдөр

Дугаар 35-1/38

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Зөвшилцөх тухай

“Даян дэлхийн ногоон хөгжлийн институтын эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хсoronдын хэлэлцээр”-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Хянан үзэж, зохих шийдвэрийг гаргаж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд



ЛОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлд:

“Х.ХЭЛЭЛЦСЭН нь:

“Даян дэлхийн ногоон хөгжлийн институтын эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай” Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээрийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо дэмжсэн тохиолдолд уг хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг ажлын журмаар гаргахаар тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

“Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхий ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээр”-ийн тухай

Даян дэлхийн ногоон хөгжлийн институт нь (ДДНХИ) нь 2012 онд НҮБ-ын Рио +20 чуулганы үеэр 16 улсын санаачилгаар албан ёсоор байгуулагдаж өнгөрсөн 8 жилийн хугацаанд нийт 37 улс гишүүн байгууллагаар элсээд байна.

ДДНХИ нь олон улсын засгийн газар хоорондын байгууллага бөгөөд хөгжиж буй орнуудад хүртээмжтэй, тогтвортой, ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор гишүүн орнуудад уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүрэг амлалтууд болон Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилладаг. Уг зорилгын хүрээнд (i) хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, (ii) ногоон ажлын байр бий болгох (iii) тогтвортой үйлчилгээ хүртэх боломжийг нэмэгдүүлэх буюу хямд, цэвэр эрчим хүчний хүртээмж, тогтвортой нийтийн тээвэр, сайжруулсан ариун цэврийн байгууламж, хог хаягдлын менежмент гэх мэт (iv) агаарын чанарыг сайжруулах (v) экосистемийн үйлчилгээний зохистой хангамж (vi) уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зэрэг үндсэн 6 чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Монгол Улс 2013 онд тус байгууллагын гишүүн улсын хэлэлцээрт гарын үсэг зуран 2014 онд үүсгэн байгуулах гэрээг баталсан. Улмаар Хөтөлбөрийн газар нь Монгол Улсын Гадаад хэргийн яамны 2014 оны 6 дугаар сарын 20-ны (А/14-873) тоот зөвшөөрлөөр Монгол Улсад үйл ажиллагаагаа эхэлсэн болно.

ДДНХИ-ийн санхүүжилтээр Монгол Улсад 2014 оноос 7 сая орчим ам.долларын ногоон хот байгуулалт, ногоон эдийн засаг, тогтвортой эрчим хүчний үүсвэрийг дэмжих чиглэлийн төслүүдийг БОАЖЯ, ЭХЯ, БХБЯ, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран хэрэгжүүлж ирсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам тус институттай хамтран ажиллах санамж бичгийг статус болон хамрах хүрээний үндэслэлээр өөрчлөлт оруулж ирсэн бөгөөд хамгийн сүүлд 2019 оны 10 дугаар сард шинэчлэн байгуулсан Санамж бичгийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улс гишүүн орны хувьд ДДНХИ-ийн эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийг зохицуулах хүрээнд хоёр талт олон улсын гэрээ болох Монгол Улсын Засгийн газартай хэлэлцээр байгуулах саналыг тавьснаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам бусад холбогдох байгууллагуудтай хамтран судлан энэ асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу гарын үсэг зурах эрхийг холбогдох албан тушаалтанд олгох, цаашид уг гэрээг соёрхон батлуулахаар бэлтгэв.

Талууд хэлэлцээрийн төслийг 2020 оны 06 дугаар сард эцэслэн тохиролцсон ба Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбоотой хэлэлцээрийн төсөлд Батлан хамгаалах яамнаас ирүүлсэн саналыг тусгасан хувилбарыг ДДНХИ-ийн

талд уламжлан 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдөр цахимаар харилцан тохиролцсон.

ДДНХИ нь өөрийн санхүүжилтээр ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудын дагуу гишүүн улсуудын Засгийн газрын хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажилладаг бөгөөд ямар нэгэн хэлбэрээр урт богино хугацааны зээл олгох зэрэг үйл ажиллагаа эрхэлдэггүй.

Уг хэлэлцээрийг Засгийн газартай байгуулснаар олон улсын засгийн байгууллагын хувьд эдлэх эрх үүрэг, дархан эрх, халдашгүй байдал болон бусад хөнгөлөлт, татварын чөлөөлөлт зэрэг асуудлаарх эрх зүйн статусаа баталгаажих үндэс болно. Ингэснээр Монгол Улсад хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, үйл ажиллагааг өргөжүүлж, санхүүжилтийг нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ТӨСӨЛ

ДАЯН ДЭЛХИЙН НОГООН ХӨГЖЛИЙН ИНСТИТУТЫН
ЭРХ ЗҮЙН СТАТУС, ЭРХ ЯМБА, ДАРХАН ЭРХИЙН ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

болон

ДАЯН ДЭЛХИЙН НОГООН ХӨГЖЛИЙН ИНСТИТУТ

хоорондын

ХЭЛЭЛЦЭЭР



65
Даян дэлхий ногоон хөгжлийн институт (ДДНХИ) нь 2012 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Рио де Жанейро хотноо “Даян дэлхий ногоон хөгжлийн институт үүсгэн байгуулах тухай” хэлэлцээрийн дагуу үүсгэн байгуулагдсан болохыг,

“ДДНХИ үүсгэн байгуулах тухай хэлэлцээр” нь 2012 оны 10 дугаар сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсныг,

Хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнуудын тогтвортой хөгжлийг дэмжих нь ДДНХИ-ийн үндсэн зорилго болохыг,

Монгол Улс нь ДДНХИ-ийн гишүүн улс бөгөөд ДДНХИ нь Монгол Улсад төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж байгааг,

ДДНХИ нь Монгол Улсад төлөөллөө хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулж байгаатай холбогдон Талууд харилцаагаа засгийн газар хоорондын олон улсын байгууллагын эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн талаарх олон улсын жишигт нийцүүлэн зохицуулах хэрэгцээ шаардлага тулгарч байгааг,

Монгол Улс болон ДДНХИ нь тус байгууллагыг Монгол Улсын нутаг дэвсгэрт болон олон улсад үйл ажиллагаа явуулах эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхтэй байж, удирдах байгууллага, ажилтан, зөвлөхүүд болон ДДНХИ-тэй холбоотой бусад этгээдийг чиг үүргээ үр дүнтэй зохих ёсоор хэрэгжүүлэх боломжийг хангахыг эрмэлзэж байгааг

тус тус ТЭМДЭГЛЭН,

Талууд дараах зүйлийг харилцан тохиролцов:

1 дүгээр зүйл
Нэр томъёоны тодорхойлолт



Энэхүү Хэлэлцээрт хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

“Хэлэлцээр” гэж Монгол Улс болон ДДНХИ-ийн хооронд байгуулсан энэхүү Хэлэлцээрийг;

“Зөвлөлдөх хороо” гэж ДДНХИ-ийн Зөвлөлдөх хороог;

“Эрх бүхий байгууллага” гэж Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх олгогдсон холбогдох байгууллагыг;

“ДДНХИ-ийн архив” гэж ДДНХИ-ийн архивын баримтыг хэлэх ба үүнд тус байгууллагын өөрийн эзэмшлийн эсхүл тус байгууллагын болон түүнийг төлөөлөн хөтлөн болговсруулсан бүх тэмдэглэл, сурвалжилга, бичиг баримт, гар бичмэл, хөдөлгөөнт зураг, дүрс бичлэг, дуут бичлэг болон бусад баримт багтана;

“Ассамблей” гэж ДДНХИ-ын Ассамблейг;

“Зөвлөл” гэж ДДНХИ-ын Зөвлөлийг;

“Хамааралтай хүүхэд” гэж ДДНХИ-ийн ажилтны гэрлээгүй, 21-ээс доош насны эсхүл бүтэн цагаар бүрэн хөтөлбөрийн дагуу суралцаж буй эсхүл хөгжлийн бэрхшээлтэй 21-23 настай хүүхдийг;

“Ерөнхий захирал” гэж Ерөнхий Ассамблейгаас томилсон ДДНХИ-ийн Ерөнхий захирлыг;

“Зөвлөх” гэж ДДНХИ-ийн хувь хүн эсхүл аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээний зохицуулалтын хүрээнд тус байгууллагад богино хугацааны ажил үйлчилгээг үзүүлж буй этгээдийг;

“ДДНХИ-ийн Суурин төлөөлөгч” гэж Суурин төлөөлөгчийн газрыг хариуцан ажиллахаар ДДНХИ-ээс томилогдсон удирдах албан тушаалтныг;

“Засгийн газар” гэж Монгол Улсын Засгийн газрыг;

“Дотоодын хууль тогтоомж” гэж Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулийг ойлгох ба үүнд Засгийн газрын эрх бүхий байгууллага, агентлаг зэрэг төрийн байгууллагаас гаргасан зарлиг, тогтоол, захирамж, дүрэм, журам, тушаал болон бусад бүх шийдвэрийн баримт бичгийг багтаана;

“ДДНХИ-ийн уулзалтууд” гэж тус байгууллагын зохион байгуулсан олон улсын бага хурал, цуглаан, комисс, хороо, дэд ажлын хэсгийн хурал болон ДДНХИ-ээс зохион байгуулах бүх уулзалтыг;

“Гэрийн ажилтан” гэж ДДНХИ-ийн бие бүрэлдэхүүний ар гэрийн үйлчилгээнд ажиллаж байгаа Монгол Улсын иргэдээс бусад ажилтанг тус тус хэлнэ;

“Албан байр” гэж ДДНХИ-ийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газрын ажлын байр буюу Хэлэлцээрийн 11 дүгээр зүйлд дэлгэрүүлж заасан утга агуулгаар ойлгож хэрэглэнэ;

“ДДНХИ-ийн албан тушаалтан” гэж ДДНХИ-ээс томилогдсон Ерөнхий захирал болон хагас, бүтэн цагаар ажиллах Зөвлөхөөс бусад бүх ажилтанг;

“ДДНХИ-ийн бие бүрэлдэхүүн” гэж Ассамблей, Зөвлөл, Зөвлөлдөх хорооны гишүүд, ДДНХИ-ийн бүх албан тушаалтан, зөвлөхийг хэлнэ. (Үүнд Монгол Улсын иргэд, гадаадын мэргэжилтнүүд эсхүл Монгол Улсад түр оршин суугч болон зөвлөхүүд багтах ба харин Монгол Улсын иргэншилтэй цагийн ажилтан үл хамаарна);

“ДДНХИ-ийн өмч” гэж өмч хөрөнгийн байршил, эзэмшлээс үл хамаарч ДДНХИ-ын сангууд, орлого, захиран зарцуулах эсхүл эзэмших эрх бүхий аливаа өмч хөрөнгийг;

“Гэр бүлийн хүн” гэж ДДНХИ-ийн албан тушаалтны албан ёсоор гэрлэлтээ бүртгүүлсэн эхнэр, нөхөр, хамтран амьдрагч эсхүл үргэлжилсэн хугацаанд хамтран амьдарч буйг нь Засгийн газрын зүгээс хүлээн зөвшөөрсөн (аливаа хүйсийн) этгээдийг

тус тус хэлнэ.



2 дугаар зүйл

Хуулийн этгээд байх. эрх зүйн чадамж


(1) Засгийн газар нь ДДНХИ-ийг олон улсын эрх зүйн чадамжтай олон улсын байгууллага гэдгийг хүлээн зөвшөөрнө.

(2) ДДНХИ нь (i) гэрээ байгуулах, (ii) эзэмших, ашиглах, захиран зарцуулах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөтэй, (iii) эрх зүйн чадвартай хуулийн этгээд байна.

(3) ДДНХИ нь олон улсын байгууллагын хувьд хараат бус байж, бие даан шийдвэр гаргах эрхтэй байна.

3 дугаар зүйл

Өмч, эд хөрөнгө



(1) ДДНХИ болон түүний бүх өмч, эд хөрөнгө тодорхой тохиолдолд дархан эрхээс татгалзаагүй л бол хаана, хэн ашиглаж байгаагаас үл хамааран аливаа хуулт хяналтын ажиллагаанд халдашгүй дархан эрх эдэлнэ. Өөрөөр заагаагүй бол дархан эрхээсээ татгалзах явдал нь албадлагын аливаа арга хэмжээнд хамаарахгүй.

(2) ДДНХИ-ийн бүх өмч, хөрөнгө хаана, хэн ашиглаж байгаагаас үл хамааран гүйцэтгэх, захиргаа, шүүхийн эсхүл хууль тогтоох ажиллагааны хүрээнд хийгдэх нэгжлэг, албадан дайчилгаа, битүүмжлэл болон хөндлөнгийн оролцооны аливаа бусад хэлбэрээс чөлөөлөгдөнө.

(3) ДДНХИ-ийн архивын баримт бичиг хаана байгаагаас үл хамааран халдашгүй байна.

(4) ДДНХИ нь санхүүгийн хяналт, дүрэм журмын эсхүл түдгэлзүүлэлтийн (moratoria) бүх хязгаарлалтаас чөлөөлөгдөх бөгөөд аливаа төрлийн валют, мөнгөн хөрөнгөтэй байх, аливаа валютын данс эзэмших, аливаа валютын гүйлгээг нэг улсаас нөгөө улс руу чөлөөтэй шилжүүлэх, хөрвүүлэх эрхтэй байна.

4 дүгээр зүйл

Татвар болон гаалийн хураамжаас чөлөөлөх

(1) ДДНХИ-ийн өмч хөрөнгө, орлого болон бусад эд хөрөнгө нь:

(a) Тодорхой төрлийн үйлчилгээний төлбөрөөс бусад бүх төрлийн шууд татвар, хураамжаас чөлөөлөгдөнө;

(b) ДДНХИ-ийн импортлох, экспортлох эд зүйлс нь зөвхөн албан хэрэгцээнд ашиглах тохиолдолд импорт, экспортын хориглолт хязгаарлалтаас чөлөөлөгдөх бөгөөд Засгийн газраас тусгайлан зөвшөөрөл аваагүй бол эдгээр эд зүйлсийг Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдахыг хориглоно;


(c) ДДНХИ-ийн албан хэрэгцээнд ашиглах зорилгоор импортоор оруулж ирэх бараа бүтээгдэхүүн нь Засгийн газраас тодорхойлох нөхцөлийг хангасан тохиолдолд гаалийн татвар хураамжаас чөлөөлөгдөнө;

(2) ДДНХИ нь үйл ажиллагаандаа зориулж худалдан авсан бараа, үйлчилгээний өртөгт шингэсэн нэмэгдсэн өртгийн албан татварыг Засгийн газрын холбогдох зохицуулалтын дагуу буцааж авах эрх эдэлнэ.

(3) ДДНХИ-ийн албан тушаалтнууд, Зөвлөхүүдэд Монгол Улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомж хамаарахгүй.

(4) ДДНХИ нь татвар, хураамж ногдуулах, хураах, хадгалах, төлөхтэй холбогдсон аливаа үүргээс чөлөөлөгдөнө.

5 дугаар зүйл Харилцаа холбоо



(1) Монгол Улс ДДНХИ-ийн албаны шуудан, харилцааны хувьд чөлөөтэй харилцахыг зөвшөөрөх бөгөөд цахим шуудан, шуудан, кабель цахилгаан мэдээ, телекс, радио, факс, утас болон бусад бүх төрлийн харилцааны хэрэгслээр харилцах болон хэвлэлд, радиод мэдээ өгөх зэрэг бололцоог бүрдүүлэхдээ харилцаа холбооны эрх, үнэ тарифын хувьд бусад олон улсын байгууллага, дипломат төлөөлөгчийн газарт олгодог нөхцөлөөс дордуулахгүй.

(2) Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ДДНХИ-ийн бүх төрлийн, бүх хэлбэрийн харилцаа, шуудан нь хяналт шалгалтын хувьд халдашгүй байх ба түүнийг аливаа хэлбэрээр саатуулж, задалж үл болно. Энэ дархан эрх нь харин ДДНХИ, Засгийн газар хооронд зөвшилцсөний дагуу авч хэрэгжүүлэх аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх арга хэмжээнд үйлчлэхгүй.

(3) ДДНХИ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт шуудан зөөгчөөр эсхүл битүүмжилсэн дугтуйгаар шуудан илгээмж илгээх, хүлээн авах, бусад харилцаа холбооны хэлбэрийг хэрэгжүүлэхдээ нууц түлхүүр үг ашиглах эрхтэй байх ба эдгээр нь дипломат шуудан, илгээмжийн адил халдашгүй, дархан эрхтэй байна. Битүүмжилсэн илгээмжийн гадна талд ДДНХИ-ийн таних тэмдэгтэй байх бөгөөд дотор нь зөвхөн албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг, зүйлийг агуулсан байна. Шуудан зөөгч нь ДДНХИ-ээс олгосон шуудан зөөгчийн үнэмлэхтэй байна.

6 дугаар зүйл

Ассамблей, уулзалт болон бага хурал зохион байгуулах эрх чөлөө

(1) ДДНХИ нь Засгийн газартай зөвшилцсөний үндсэн дээр Монгол Улсын нутаг дэвсгэрт уулзалт, хурал зохион байгуулах эрхтэй байна.

(2) ДДНХИ болон түүний бие бүрэлдэхүүн нь уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, шийдвэр гаргах эрх чөлөөг эдэлнэ. Монгол Улсын нутаг дэвсгэрт ДДНХИ-ийн зохион байгуулах арга хэмжээ аливаа саадгүй хэрэгжих нөхцөлийг хангахын тулд Засгийн газар бүх арга хэмжээг авна.

(3) ДДНХИ-ийн зохион байгуулах уулзалт, хурлын бүх зочин, оролцогчид нь Монгол Улсын хилээр нэвтрэх болон гарах эрхтэй байх бөгөөд тухайн уулзалт, хурал зохион байгуулагдаж буй танхим, газар руу зорчих, нэвтрэхэд саад учруулж үл болно. Тэдэнд хурдан зорчих боломжийг олгоно. Виз болон хилээр нэвтрэх зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тэдэнд шуурхай олгож, хураамжаас чөлөөлнө.

Гарын үсэг /Signature/

2021 оны 3 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

7 дугаар зүйл
Туг, таних тэмдэг

ДДНХИ нь өөрийн туг болон бусад таних тэмдгийг тус газрын байр, тээврийн хэрэгсэлдээ зүүх, байрлуулах эрхтэй.

8 дугаар зүйл

ДДНХИ-ийн гишүүн улсын Төлөөлөгчид, ДДНХИ-ийн Ассамблей, Зөвлөл, Зөвлөлдөх хорооны бүрэлдэхүүний эрх ямба, дархан эрх

(1) ДДНХИ-ийн гишүүн улсын төлөөлөгчид болон Ассамблей, Зөвлөл, Зөвлөлдөх хорооны бүрэлдэхүүнд байдаг хүмүүс албан үүргээ гүйцэтгэхэд болон тус байгууллагын хурал, уулзалтад оролцохоор зорчихдоо дараах эрх ямба, дархан эрх эдэлнэ. Үүнд:

а. Албан үүргээ гүйцэтгэх явцад нь баривчлах, албадан саатуулахыг хориглох, бичгээр эсхүл аман хэлбэрээр илэрхийлсэн үг, үйлдлийнх нь төлөө хариуцлага хүлээлгэхгүй. (Үүнд замын хөдөлгөөний хууль, дүрэм, журмыг зөрчсөн үйлдэл, өөрөө жолоодож явсан эсхүл түүний өмчлөлийн тээврийн хэрэгслээр бусдад учруулсан хохиролтой холбогдуулан гарсан нэхэмжлэл хамаарахгүй);

б. Дипломат харилцааны тухай Венийн конвенцийн 36 дугаар зүйлийн 2-т заасны дагуу хувийн ачаа тээшийг нь үзлэгээс чөлөөлнө;

в. Өөрөө болон дагалдан яваа гэр бүлийн гишүүд хил нэвтрэх хязгаарлалт болон гадаадын иргэний бүртгүүлэх үүргээс чөлөөлөгдөнө;

г. Гадаадын Засгийн газрын байгууллагын төлөөлөгчдөд албан томилолтоор түр зорчих хугацаанд үзүүлдгийн адил нөхцөлөөр гадаадын мөнгөн тэмдэгт ба валют ашиглах эрхийг эдлүүлнэ;

д. ДДНХИ-ийн Ассамблей, Зөвлөл болон Зөвлөлдөх хорооны гишүүд, төлөөлөгчид ДДНХИ-ийн уулзалт, арга хэмжээнд оролцох зорилгоор Монгол Улсад зорчих тохиолдолд ДДНХИ визийн мэдүүлгийг бэлтгэн Монголын талтай шуурхай зөвшилцөж ажиллана.

(2) 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг нь Монгол Улсын төлөөлөгчдөд үл хамаарна.

(3) ДДНХИ нь 8 дугаар зүйлийн үйлчлэлд хамаарах албан тушаалтан, төлөөлөгчдийн нэрсийг Засгийн газарт тогтмол мэдэгдэж байна.

9 дүгээр зүйл

ДДНХИ-ийн албан тушаалтны эрх ямба, дархан эрх

(1) ДДНХИ-ийн албан тушаалтан нь:

а. Албан үүргээ гүйцэтгэх хүрээнд хийсэн үйлдлийнх нь төлөө шүүхийн болон аливаа бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хариуцлагад татаж үл болно. Энэхүү заалт нь тухайн албан тушаалтны үйлдсэн аливаа санаатай, санаандгүй болон гэмт хэргийн шинжтэй хэрэг, залилан мэхлэх сэдэлтэй

хэргийнх нь улмаас үүссэн хохирлыг барагдуулах хариуцлагад нь хамаарахгүй;

б. ДДНХИ-ээс олгох цалин хөлс, мөнгөн тэтгэмж, шагнал урамшуулал нь бүх төрлийн татвар, хураамжаас чөлөөлөгдөнө;

в. Нийгмийн хамгааллын асуудлаарх зохицуулалтад үл хамрагдана;

г. гэр бүлийн хүн, хүүхдүүдийн хамт Монгол Улсад зорчих, хил нэвтрэх нийтлэг хязгаарлалтаас болон гадаад иргэдийн бүртгэлд бүртгүүлэх үүргээс чөлөөлөгдөнө;

д. Дипломат төлөөлөгчийн газрын адилтгах түвшний албан тушаалтанд олгогддог гадаад валют солих эрхийг адил эдэлнэ;

е. гэр бүлийн хүн, хүүхдүүдийн хамт дипломат төлөөлөгчийн газрын адилтгах түвшний албан тушаалтны олон улсын хямралын үед эх орондоо буцах эрхийг адил эдэлнэ;

ё. Монгол Улс дахь Төлөөлөгчийн газарт томилогдох үедээ тавилга, гэр ахуйд зориулсан эд юмсыг аливаа татваргүй нэвтрүүлэх эрхтэй;

ж. Монгол Улс дахь Төлөөлөгчийн газарт ажиллахаар томилогдсон этгээд анх суурьших үедээ Засгийн газраас заасан нөхцөл болзолд нийцүүлэн хувийн хэрэгцээний автомашиныг аливаа татваргүй оруулах эрхтэй;

з. Монгол Улсын иргэнд болон Монгол Улсад байнгын оршин суугчид 9 дүгээр зүйл хамаарахгүй.

(2) Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 1-р хэсэгт заасан эрх ямба, дархан эрхээс гадна ДДНХИ-ийн Ерөнхий захирал, Дэд захирлууд, Ерөнхий захирлын туслахууд, ДДНХИ-ийн Төлөөлөгчийн газрын тэргүүн, тэдгээрийн гэр бүлийн хүн, хүүхдүүдэд олон улсын эрх зүйн дагуу дипломат төлөөлөгчийн газрын бүрэлдэхүүнд олгодогтой адил эрх ямба, дархан эрх, хөнгөлөлтийг эдлүүлнэ.

(3) ДДНХИ нь Хэлэлцээрт заасан давуу эрх, эрх ямба, дархан эрхийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг хууль ёсны дагуу хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газрын зохих байгууллагуудтай хамтран ажиллана.

10 дугаар зүйл

Зөвлөхүүдийн эрх ямба, дархан эрх 2024 оны 3 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

(1) ДДНХИ-ийн Зөвлөхүүдэд албан томилолтын хугацаанд ажил үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай дараах эрх ямба, дархан эрхийг эдлүүлнэ.
Үүнд:

а. Албан үүргээ гүйцэтгэх хүрээнд хийсэн үйлдлийнх нь төлөө шүүхийн болон аливаа бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хариуцлагад татаж үл болно. Энэхүү заалт нь тухайн албан тушаалтны үйлдсэн аливаа санаатай, санаандгүй

Гарын үсэг /Signature/

2024 оны 3 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

71

болон гэмт хэргийн шинжтэй хэрэг, залилан мэхлэх сэдэлттэй хэргийнх нь улмаас үүссэн хохирлыг барагдуулах хариуцлагад нь хамаарахгүй;

б. Дипломат төлөөлөгчийн газрын адилтгах түвшний албан тушаалтанд олгогддог гадаад валют солих эрхийг адил эдлүүлнэ;

в. Эхнэр, нөхөр, хүүхдүүдийн хамт Монгол Улсад зорчих, хил нэвтрэх нийтлэг хязгаарлалтаас болон гадаад иргэдийн бүртгэлд бүртгүүлэх үүргээс чөлөөлөгдөнө.

11 дүгээр зүйл **Төлөөлөгчийн газар**

(1) Засгийн газраас олгосон зөвшөөрлийн дагуу ДДНХИ нь Монгол Улсад Төлөөлөгчийн газраа байгуулж болно ("Төлөөлөгчийн газрын албан байр").

(2) Төлөөлөгчийн газарт ДДНХИ-ээс томилогдсон албан тушаалтнууд болон зөвлөхүүд ажиллана.

(3) Хэрэв энэхүү Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Төлөөлөгчийн газарт Монгол Улсын хууль тогтоомж үйлчлэх ба Төлөөлөгчийн газарт болсон үйлдэл Монгол Улсын шүүхийн харьяалалд хамаарна.

(4) Төлөөлөгчийн газрын байр ДДНХИ-ийн удирдлага, хяналтад байх ба халдашгүй эрхтэй байна. Монгол Улсын аливаа эрх бүхий байгууллага ДДНХИ-ийн зөвшөөрөлгүйгээр, тохиролцсон нөхцөлийг үл харгалзан Төлөөлөгчийн газрын байранд нэвтрэх, ямар нэг үүрэг гүйцэтгэхийг хориглоно. ДДНХИ-д урьдчилан бичгээр мэдэгдэл хүргүүлэхгүйгээр Төлөөлөгчийн газрын байранд галын аюулаас хамгаалах, ариун цэвэр халдваргүйжүүлэлт хийх эсхүл онцгой байдлын шаардлагаар нэвтрэх нөхцөл, нэвтрэх үед баримтлах журмыг ДДНХИ, Засгийн газар харилцан тохиролцоно.

(5) Төлөөлөгчийн газар нь Монгол Улс дотор болон хилийн чанадад харилцаа холбоогоо явуулах, нэг цэгээс нөгөө цэгт мэдээлэл хүргэх теле болон бусад харилцаа холбооны төхөөрөмж, дамжуулах холболтыг суурилуулж ажиллуулах эрхтэй.

(6) ДДНХИ нь Төлөөлөгчийн газрынхаа чиг үүрэг, үйл ажиллагааг бие даасан, иж бүрэн хэрэгжүүлэх зорилгоор дотоод дүрэм журам боловсруулж, мөрдүүлэх эрхтэй. Энэхүү дүрэм, журам нь Монгол Улсын хууль тогтоомжтой зөрчилдөх тохиолдолд Төлөөлөгчийн газар ДДНХИ-ийн дүрэм журмыг баримтлах эрхтэй.

(7) ДДНХИ нь Төлөөлөгчийн газрын байранд уулзалт, хурал зохион байгуулах эрхтэй.

(8) Төлөөлөгчийн газрын байрыг ДДНХИ-ийн үндсэн зарчим, үйл ажиллагаанд нийцүүлэн ашиглана. ДДНХИ нь Төлөөлөгчийн газрыг хууль хяналтаас зайлсхийсэн этгээд, шилжүүлэх ёстой гэмт этгээд орогнуулах, хуулийн хариуцлагаас болон шүүхийн ажиллагаанаас зайлсхийсэн этгээдийг орогнуулдаг байр болгохгүйн тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

Гарын үсэг /Signature

2024 оны 3 сарын 16 өдөр

Улаанбаатар хот

(9) Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллагууд Төлөөлөгчийн газрын албан байранд аливаа этгээд зөвшөөрөлгүй нэвтрэн орох эсхүл ойр орчмын амгалан тайван байдлыг алдагдуулахаас сэргийлэх чиглэлээр ажиллана.

(10) ДДНХИ-ийн хүсэлтийн дагуу Монгол Улсын эрх бүхий байгууллага Төлөөлөгчийн газрын албан тасалгаанд дэг журам сахиулах, зөрчил гаргагчдыг албадан гаргах зайлшгүй арга хэмжээний хүрээнд цагдаагийн байгууллагын зохих бие бүрэлдэхүүнийг ажиллуулна.

12 дугаар зүйл

Дамжин өнгөрөх ба оршин суух

(1) Монгол Улс дахь Төлөөлөгчийн газарт ажиллахаар томилогдсон дараах хүмүүст тухайн иргэний харьяаллаас үл хамаарч, ямар нэгэн хязгаарлалтгүйгээр Монгол Улсад орох, гарах, улс дотор чөлөөтэй зорчиход шаардлагатай бүх арга хэмжээг Засгийн газар авна. Үүнд:

а. ДДНХИ-ийн зохион байгуулах хурал, уулзалт болох газар руу явах, буцах албан тсмилолт, ажил үүргээ хэрэгжүүлж буй ДДНХИ-ийн гишүүн орны төлөөлөгчид, Ассамблей, Зөвлөл болон Зөвлөлдөх хорооны бүрэлдэхүүн;

б. ДДНХИ-ийн албан тушаалтнууд;

в. Зөвлөхүүд;

г. гэр бүлийн хүн, хүүхдүүд

д. ДДНХИ-ээс албан шугамаар хүрэлцэн ирсэн бусад этгээд. Эдгээр хүмүүсийн нэрсийг Засгийн газарт мэдэгдэж хүргүүлнэ.



(2) Засгийн газар энэхүү Хэлэлцээрийн 12 дугаар зүйлд заасан аливаа этгээдэд төлбөр хураамжгүй, саад учруулахгүй энгийн нөхцөлд зайлшгүй биечлэн ирэхийг шаардахгүйгээр виз олгох тухай ерөнхий чиглэлийг Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газар, консулын газар болон Монгол Улсыг төлөөлж буй бусад зохих байгууллагуудад өгнө.

13 дугаар зүйл

Эрх ямба, дархан эрхээс татгалзах, түдгэлзүүлэх

(1) Энэхүү Хэлэлцээрээр эрх ямба, дархан эрхийг олгохдоо тухайн этгээдийн хувийн ашиг хонжоо олоход нь бус ДДНХИ-ийн ажлын ашиг сонирхолд зориулан олгосон болно. Эдгээр эрх ямба, дархан эрх эдлэх хүмүүс Монгол Улсын хууль тогтоомжийг чандлан мөрдөх үүрэгтэй. Хэрэв эрх ямба, дархан эрх нь тодорхой тохиолдолд шударга ёсыг хэрэгжүүлэхэд саад болж байгаа хэмээн үзвэл дараах эрх бүхий этгээд дор дурдсан хувь хүмүүсийн эрх ямба, дархан эрхийг ДДНХИ-ийн ашиг сонирхолд харшлахгүйгээр түдгэлзүүлэх эрхтэй. Үүнд:

а. ДДНХИ-ийн гишүүн улс нь Ассамблей болон Зөвлөлд ажиллаж буй өөрийн төлөөлөгчийн;

б. Ассамблей нь ДДНХИ-ийн Ерөнхий захирлын;

в. Зөвлөл нь төрд алба хашдаггүй Зөвлөл болон Зөвлөлдөх хорооны гишүүд эсвэл зөвлөхүүдийн;

г. ДДНХИ-ийн Ерөнхий захирал ДДНХИ-ийн албан тушаалтнууд (өөрөөс бусад), зөвлөхүүд болон ДДНХИ-ийн бүтэн байгууллагынх нь хувьд;

(2) Дээрхи бүх тохиолдолд татгалзах/түдгэлзүүлэх шийдвэрийг зөвхөн бичгэн хэлбэрээр илэрхийлж үйлдэнэ.

14 дүгээр зүйл

Хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэх асуудлаар гарсан маргааныг зохицуулах

(1) Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэхтэй холбогдон гарсан аливаа зөрчил, маргааныг зөвшилцөл, хэлцэл болон харилцан тохиролцсон бусад арга замаар шийдвэрлэнэ.

(2) Аливаа маргааны талаар аль нэг тал нөгөө талдаа бичгээр хүсэлт илгээснээс хойш 3 сарын дотор 14 дүгээр зүйлийн (1)-р хэсэгт заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй тохиолдолд аль ч тал тус маргааныг талуудын тохиролцон байгуулах Арбитрын шүүхээр шийдвэрлүүлэхээр хандаж болно.

(3) Арбитрын ажиллагааг англи хэл дээр явуулна.

(4) Арбитрын шүүх маргааныг энэхүү Хэлэлцээрийн зүйл, заалт болон олон улсын эрх зүйн зохицуулалтыг үндэслэн шийдвэрлэнэ. Арбитрын шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байх бөгөөд шийдвэрийг талууд заавал биелүүлнэ.

15 дугаар зүйл

Ерөнхий зүйл

(1) Энэхүү Хэлэлцээрийн заалтууд нь Засгийн газар болон ДДНХИ хооронд байгуулсан аливаа бусад гэрээ, хэлэлцээрийн хүрээнд тохиролцсон эсхүл тохиролцож болох ДДНХИ-ын эрх ямба, дархан эрх, хөнгөлөлт эсхүл төрөл бүрийн дэмжлэг, хувь нэмрийг үл хязгаарлана.

(2) Энэхүү Хэлэлцээр нь "ДДНХИ Үүсгэн байгуулах тухай хэлэлцээр"-ийн зүйл заалтыг эсхүл ДДНХИ-ын өөр байдлаар хүлээн авч болох аливаа эрх, үүргийг үгүйсгэх, тэдгээрийг доогуур үнэлэх байдлаар тайлбарлагдахгүй.

(3) Засгийн газар, ДДНХИ нь энэхүү Хэлэлцээрийн хүрээнд шаардлагатай нэмэлт гэрээ, хэлэлцээрийг байгуулж болно.

16 дугаар зүйл

Хэлэлцээр хүчин төгөлдөр болох

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН

Борлуулсан /Signature/ 
2021 оны 3 сарын 16 өдөр

74
Хэлэлцээр талуудын гарын үсэг зурсан сүүлийн өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТОЛЖ: Монгол Улсын болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институтын бүрэн эрхт төлөөлөгчид Хэлэлцээрт гарын үсэг зурав.
Энэхүү Хэлэлцээрийг англи болон монгол хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Хэрэв монгол, англи хэл дээрх эх бичвэр хооронд зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:

ДАЯН ДЭЛХИЙ НОГООН ХӨГЖЛИЙН
ИНСТИТУТЫГ ТӨЛӨӨЛЖ:

Огноо:

Огноо:



ТӨСӨЛ

AGREEMENT

between

MONGOLIA

and

THE GLOBAL GREEN GROWTH INSTITUTE

**REGARDING THE LEGAL STATUS AND PRIVILEGES AND IMMUNITIES
OF THE GLOBAL GREEN GROWTH INSTITUTE**

**AGREEMENT BETWEEN MONGOLIA AND THE GLOBAL GREEN GROWTH INSTITUTE
REGARDING THE LEGAL STATUS AND PRIVILEGES AND IMMUNITIES OF THE GLOBAL
GREEN GROWTH INSTITUTE**

WHEREAS the Global Green Growth Institute ("GGGI") was established as an international organization by the Agreement on the Establishment of the Global Green Growth Institute (the "Establishment Agreement") at Rio de Janeiro on 20 June 2012;

WHEREAS the Establishment Agreement entered into force on 18 October 2012;

WHEREAS GGGI's primary objective is to promote sustainable development of developing and emerging countries, including the least developed countries;

WHEREAS, Mongolia is a member country of GGGI and GGGI has a physical presence and undertakes activities in Mongolia;

WHEREAS the parties are cognizant of the need to regulate their relationship in relation to GGGI's physical presence and activities in the country, in accordance with international practice relating to the legal status and privileges and immunities of intergovernmental organizations;

WHEREAS Mongolia and GGGI desire to ensure that GGGI possesses the legal status and privileges and immunities to operate within its territory and internationally and to efficiently and properly exercise its functions, including in respect of its governing organs, its personnel and experts, and other persons associated with the organization;

NOW THEREFORE the parties to this Agreement hereby agree as follows:

Article 1

Definitions

Whenever used in this Agreement, the following terms have the following meanings:

"Agreement" shall mean this Agreement between Mongolia and GGGI;

"Advisory Committee" shall mean the Advisory Committee of GGGI;

"appropriate authorities" shall mean such authorities in Mongolia as may be appropriate in the context and in accordance with the laws and customs applicable in Mongolia;

"archives of GGGI" shall mean all archives of GGGI, and includes all records, correspondence, documents, manuscripts, moving pictures, films, sound recordings and other materials belonging to GGGI, or held by or on behalf of GGGI;

"Assembly" shall mean the Assembly of GGGI;

"Council" shall mean the Council of GGGI;

"dependent children" shall mean children of Personnel of GGGI who are unmarried and under the age of 21 years old; or unmarried children between the ages of 21 and 23 years old who are undertaking full-time studies or who are disabled;

"Director-General" shall mean the Director-General of GGGI appointed by the Assembly;

"Expert" shall mean any individual providing short-term services to GGGI under contractual arrangements between the individual and GGGI or between an entity and GGGI;

"GGGI Representative" means the senior official appointed by GGGI to be the head and in charge of the Office;

"Government" shall mean the Government of Mongolia;

"laws of country" shall mean the constitution and laws of Mongolia and includes, without limitation, statutes, decrees, ordinances, rules, regulations, orders and other instruments issued by or under the authority of the Government and its agencies;

"meetings convened by GGGI" shall mean meetings of GGGI, including any international conference or other gathering convened by GGGI, and any commission, committee or sub-group of any of such meetings;

"members of household staff" shall mean persons, other than nationals of Mongolia, employed in the domestic staff of Personnel of GGGI;

"Office" shall mean an office of GGGI in Mongolia, as further elaborated in Article 11 hereof;

"Officials of GGGI" shall mean the Director-General, the GGGI Representative, and all persons appointed or engaged to work full time or part time for GGGI, but does not include Experts;

"Personnel of GGGI" shall mean all members of the Assembly, the Council and the Advisory Committee, Officials of GGGI (both expatriates and nationals or permanent residents of Mongolia and Experts, but not locally recruited persons paid at an hourly rate.

"property of GGGI" shall mean all property and assets of GGGI, wheresoever located and by whomsoever held and includes funds, income and rights belonging to, or held or administered by, GGGI; and

“spouse” shall mean a partner (of whatever sex) of Personnel of GGGI if they have registered their relationship, or who continuously share a household if such relationship is recognized by the Government.

Article 2

Legal Personality and Capacities

(1) The Government recognizes that GGGI is an international organization with international legal personality.

(2) GGGI shall be accorded with juridical personality and the legal capacity to (i) to contract, (ii) to acquire and dispose of immovable and movable property and (iii) to institute legal proceedings.

(3) GGGI shall have the independence and freedom of action belonging to an international organization.

Article 3

Property, Funds and Assets

(1) GGGI and its property and assets, wherever located and by whomsoever held, shall enjoy immunity from every form of legal process, except in so far as in a particular case it has expressly waived its immunity. It is, however, understood that no waiver of immunity shall extend to any measure of execution, unless explicitly stated otherwise.

(2) The property and assets of GGGI, wherever located and by whomsoever held, shall be immune from search, requisition, confiscation, expropriation or any other form of interference, whether by executive, administrative, judicial or legislative action.

(3) The archives of GGGI shall be inviolable, wherever located.

(4) Without being restricted by financial controls, regulations or moratoria of any kind, GGGI may hold funds or currency of any kind; operate accounts in any currency; and freely transfer any currencies it holds from one country to another and freely convert any currency held by it into any other currency.

Article 4

Exemption from Taxation and Customs Duties

(1) GGGI, its assets, income, and other property shall be:

(a) exempt from all direct taxes except those which are, in fact, no more than charges for specific services rendered;

- (b) exempt from prohibitions and restrictions on imports and exports in respect of articles imported or exported by GGGI for its official use and in the case of any publications of GGGI imported or exported by it; it is understood, however, that articles imported under such exemption will not be sold in the territory of the Mongolia except under conditions agreed to with the Government;
- (c) exempt from customs duties on the importation of goods imported by or on behalf of GGGI for its official use, or on the importation of any publications of the organisation imported by it or on its behalf, subject to compliance with such conditions as the Government may prescribe; and

(2) GGGI shall have relief, under arrangements made by the Government, by way of refund of value added tax paid on the supply of any goods and services of substantial value which are necessary for the official activities of the organization, such relief to be subject to compliance with such conditions as may be imposed by the Government in accordance with the arrangements.

(3) GGGI, its Officials and Experts shall not be subject to regulations on labor and social security in Mongolia.

(4) GGGI shall be exempt from any obligation in connection with the payment, withholding or collection of any tax or duty.

Article 5

Communications

(1) Official communications of GGGI shall be accorded by Mongolia treatment not less favorable than that accorded by the Government to any other international organization or government including any of the diplomatic missions based in the country, in the matter of priorities, rates and surcharges on emails, surface mail, cables, telegrams, telexes, radiograms, telefax, telephone and other means of communications, and press rates for information to the press and radio.

(2) All communications to, from and through the territory of Mongolia by whatever means or in whatever form transmitted shall be immune from censorship and any other form of interception or interference with their privacy. This does not preclude the adoption of appropriate security precautions to be determined after consultation between the Government and GGGI.

(3) GGGI shall have the right in Mongolia to use codes and to dispatch and receive correspondence and other communications either by courier or in sealed bags which shall have immunities and privileges not less favorable than those accorded to diplomatic couriers and bags. The bags must bear visibly GGGI

emblems and shall contain only documents or articles intended for official use, and the courier shall be provided with a courier certificate issued by GGGI.

Article 6

Freedom of Assembly, Meetings and Conferences

(1) In consultation with the Government, GGGI shall have the right to convene meetings in Mongolia.

(2) GGGI and its personnel shall enjoy full freedom of meeting, discussion and decision. The Government shall take all necessary measures to ensure that no impediment is placed in the way of meetings convened by GGGI within Mongolia.

(3) All persons invited and accredited for a meeting or conference organized by GGGI, shall have the right of entry into and exit from Mongolia, and no impediment shall be imposed on their transit to, and from, the premises of the meeting or conference. They shall be granted facilities for speedy travel. Visas and entry permits, where required, shall be granted free of charge as speedily as possible in accordance with applicable law.

Article 7

Flag, Emblem and Markings

GGGI shall have the right to display its flag and/or other identifiers on its premises and vehicles.

Article 8

Privileges and Immunities of Representatives of GGGI Members and Other Persons Constituting the Assembly, Council, and Advisory Committee of GGGI

(1) Representatives of GGGI Members and other persons constituting the Assembly, Council, and Advisory Committee shall, while exercising their functions and during their journeys to and from the place of meetings convened by GGGI, enjoy the following privileges and immunities:

- (a) immunity from personal arrest or detention and immunity from legal process in respect of words spoken or written and all acts done by them in their official capacity (this immunity from legal process shall not apply to the above persons in the case of motor traffic offences committed by them or in the case of damage caused by a motor vehicle belonging to or driven by them);

- (b) the like exemption and privileges in respect of their personal baggage in accordance with paragraph 2 of Article 36 of the Vienna Convention on Diplomatic Relations;
 - (c) immunity, together with their spouses and dependent children, from immigration restrictions and alien registration requirements;
 - (d) the same facilities in respect of currency and exchange restrictions as are accorded to representatives of foreign Governments on temporary official missions; and
 - (e) where persons constituting the Assembly, Council, and Advisory Committee are required to travel to attend GGGI meetings then all applications for visas made by GGGI shall be dealt with by Mongolia as speedily as possible.
- (2) The provisions of Article 8(1) is not applicable in relation to representatives of Mongolia.
- (3) GGGI shall regularly make known to the Government the names of the officials to whom the provisions of this Article apply.

Article 9

Privileges and Immunities of Officials of GGGI

- (1) Officials of GGGI shall:
- (a) be immune from suit and from other legal process in respect of acts and things done in their official capacity. However, this provision will not relieve any person from liability for any damage arising from any criminal act, gross or willful negligence or fraudulent act);
 - (b) be exempt from all forms of taxation on or in respect of salaries, allowances, and emoluments paid to them by GGGI;
 - (c) not be subject to regulations on social security;
 - (d) be immune, together with their spouses and dependent children, from immigration restrictions and alien registration;
 - (e) be accorded the same privileges in respect of exchange facilities as are accorded to officials of comparable rank of diplomatic missions;
 - (f) be given, together with their spouses and dependent children, the same repatriation facilities in time of international crises as officials of comparable rank of diplomatic missions;

- (g) have the right to import free of duty their furniture, household goods, and effects at the time of first taking up their official post in the Office in Mongolia; and
- (h) have the right to import free of duty a vehicle for their personal use at the time of taking up their official post in the Office in Mongolia, subject to compliance with such conditions as the Government may prescribe.
- (i) article 9 does not apply to a citizen of Mongolia or a permanent resident of Mongolia.

(2) In addition to the immunities and privileges specified in Articles 9(1) and the Director-General, the Deputy Director-Generals, the Assistant Director-Generals of GGGI, and the GGGI Representative shall be accorded in respect of themselves, their spouses and dependent children, the privileges and immunities, exemptions and facilities accorded to diplomatic envoys, in accordance with international law.

(3) GGGI shall co-operate with the appropriate authorities of the Government to facilitate the proper administration of justice and prevent the occurrence of any abuses in connection with the privileges, immunities, and facilities mentioned in this Article.

Article 10

Privileges and Immunities of Experts

(1) Experts for GGGI shall be accorded the following privileges and immunities as are necessary for the effective exercise of their functions, including during journeys made in connection with their service:

- (a) immunity from from suit and from other legal process in respect of acts and things done in their official capacity. However, this provision will not relieve any person from liability for any damage arising from any criminal act, gross or willful negligence or fraudulent
- (b) the same facilities in respect of currency and exchange restrictions as are accorded to representatives of foreign Governments on temporary official missions; and
- (c) immunity, together with their spouses and dependent children, from immigration restrictions and alien registration.

Article 11

Office Premises

(1) With the agreement of the Government, GGGI may establish an office in Mongolia (the "Office").

(2) The Office shall be staffed with such Officials of GGGI and Experts as may be assigned thereto.

(3) Except as otherwise provided in this Agreement, the laws of Mongolia shall apply within the Office, and the courts of Mongolia shall have jurisdiction over acts done in the Office.

(4) The Office premises shall be inviolable and shall be under the control and authority of GGGI. No authorities of Mongolia shall enter the Office premises to perform any duties therein without the consent of, and under conditions agreed to by GGGI. GGGI and the Government shall agree under what circumstances and in what manner the authorities of Mongolia may enter the Office premises without prior consent of GGGI in connection with fire prevention, sanitary regulations or emergencies.

(5) GGGI shall have the right to install and operate in Mongolia point-to-point telecommunication facilities and other communication and transmission facilities as may be necessary to facilitate communications with the Office both from within and outside Mongolia.

(6) GGGI shall have the power to make rules and regulations operative within the Office premises for the full and independent exercise of its operations and performance of its functions. In the event of conflict between such GGGI rules and regulations and the laws of Mongolia, GGGI's rules and regulations shall prevail.

(7) GGGI shall have the right to convene meetings within the Office premises.

(8) The Office premises shall be used in a manner compatible with GGGI's purposes and functions. GGGI shall prevent the Office premises from becoming a refuge for fugitives from justice, or for persons subject to extradition, or persons avoiding service of legal process or a judicial proceeding.

(9) The appropriate authorities of Mongolia shall exercise due diligence to ensure that the tranquility of the Office premises is not disturbed by any person attempting unauthorized entry or creating disturbances in the immediate vicinity of the Office premises.

(10) If so requested by GGGI, the appropriate authorities of Mongolia shall provide a sufficient number of police for the preservation of law and order in the Office premises and for the removal therefrom of offenders.

Article 12

Transit and Residence

(1) The Government shall take all measures required to facilitate the entry into, departure from and freedom of movement in Mongolia, and, with regard to persons assigned to the Office, residence in Mongolia, of the following persons without any restriction and irrespective of nationality:

- (a) Representatives of GGGI members and other persons constituting the Assembly, the Council and Advisory Committee, while exercising their functions and during their journeys to and from the place of meetings convened by GGGI;
- (b) Officials of GGGI;
- (c) Experts;
- (d) the spouse and dependent children, and members of the household staff of Officials and Experts of GGGI assigned to the Office; and
- (e) Other persons invited by GGGI on official business. GGGI shall communicate the names of such persons to the Government.

(2) The Government shall issue to its embassies, legations, consulates and any other offices representing the interests of Mongolia general instructions to grant, if necessary, visas to any persons referred to in this Article 12 without any delay, waiting period, or payment of any charges, and without ordinarily requiring their personal presence.

Article 13

Waiver of Privileges and Immunities

(1) The privileges and immunities granted by this Agreement to persons are conferred in the interest of GGGI and not for the personal benefit of the individuals themselves. It is the duty of all persons enjoying such privileges and immunities to observe in all other respect the laws and regulations of Mongolia. The following authorities have the right and the duty to waive immunities of the following persons in a particular case where, in their opinion, the immunity would impede the course of justice and can be waived without prejudice to the interests of GGGI:

- (a) the Members of GGGI, with respect to their representatives on the Assembly and Council;
- (b) the Assembly, with respect to the Director-General of GGGI;
- (c) the Council, with respect to the experts or non-state actors who serve as members of the Council or Advisory Committee; and

85

(d) the Director-General of GGGI, with respect to Officials of GGGI (other than him/herself), Experts and GGGI itself.

(2) In all cases a waiver must be expressly made in writing.

Article 14

Settlement of Differences on the Interpretation or Application of the Present Agreement

(1) All differences arising out of the interpretation or application of this Agreement shall be settled by consultation, negotiation or other agreed mode of settlement.

(2) If the difference is not settled in accordance with Article 14(1) within three months following a written request by one of the parties, then either party may request that the difference be referred for decision by an arbitral tribunal to be established by the parties according to the procedure to be agreed by the parties.

(3) The language to be used in the arbitral proceedings shall be English.

(4) The arbitral tribunal shall reach a decision on the difference on the basis of the provisions of the present Agreement and the applicable rules of international law. The decision of the arbitral tribunal shall be final and binding on the parties to the difference.

Article 15

General Provisions

(1) The provisions of this Agreement shall in no way be construed to limit or prejudice the privileges, immunities, exemptions, or various types of supports or contributions for GGGI, which have been, or may hereafter be, agreed between the Government and GGGI in any separate agreement.

(2) This Agreement shall not be construed so as to abrogate, or derogate from, any provisions of the Establishment Agreement or any rights or obligations which GGGI may otherwise have, acquire, or assume.

(3) The Government and GGGI may enter into such supplementary agreements as may be necessary within the scope of this Agreement.

Article 16

Entry into Force

This Agreement shall enter into force upon the last date of signature by the parties hereto.

IN WITNESS WHEREOF Mongolia and the Global Green Growth Institute, each acting through its duly authorized representative, have signed this Agreement in two equally valid originals in the English language and two equally valid originals in the Mongolian language on the respective dates indicated below. In the event of any conflict between the Mongolian and the English versions, the English version shall prevail.

ON BEHALF OF THE
GOVERNMENT OF MONGOLIA

ON BEHALF OF THE GLOBAL
GREEN GROWTH INSTITUTE

Date:

Date:

ТАНИЛЦУУЛГА

2021.04.01

Монгол Улсад суугаа гадаад улсын ЭСЯ, Ерөнхий консулын газар, НҮБ-ын системийн байгууллагын төлөөлөгчийн газар болон тэдгээрийн ажилтнууд нь Монгол Улсын нэгдэн орсон “Дипломат харилцааны тухай Венийн конвенц”, “НҮБ-ын төрөлжсөн байгууллагын дархан эрх, эрх ямбын тухай конвенц”, “Консулын харилцааны тухай Венийн конвенц”-уудын дагуу дархан эрх, эрх ямба эдэлдэг.

Олон улсын байгууллагын тухайд тухайн байгууллагын үүсгэн байгуулсан эрх зүйн баримт бичигт заасны дагуу дархан эрх, эрх ямба эдэлдэг

Даян дэлхийн ногоон хөгжлийн институт нь НҮБ-ын системийн байгууллагад хамаарахгүй ба олон улсын гэрээгээр байгуулагдсан Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод төв оффис нь байрладаг Засгийн газар хоорондын байгууллага юм. Тус олон улсын байгууллага нь 2012 оны 6 дугаар сарын 20-ны өдөр НҮБ-ын Рио +20 чуулганы үеэр 16 улсын санаачилгаар байгуулагдсан. Улмаар Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийг үүсгэн байгуулах тухай хэлэлцээр нь 2012 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2013 оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд улс орнуудад нэгдэн ороход нээлттэй байсан.

Монгол Улсын Засгийн газраас “Даян дэлхийн ногоон өсөлтийн хүрээлэнг үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт” гарын үсэг зурах бүрэн эрхийг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд олгосноор 2013 оны 6 дугаар сарын 9-ний өдөр хэлэлцээрт гарын үсэг зурж, Монгол Улс гишүүнээр элссэн. Монгол Улсын Засгийн газрын /Н.Алтанхуяг сайдын Засгийн газар/ 2014 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 160 дугаар тогтоолоор үүсгэн байгуулах хэлэлцээрийг баталсан.

Гадаад харилцааны яамнаас 2014 оны 5 дугаар сарын 19-ний өдөр “Даян дэлхийн ногоон өсөлтийн хүрээлэнг үүсгэн байгуулах тухай хэлэлцээр” хүчин төгөлдөр болх дотоодын процедурыг хангасан болохыг нотлох албан бичгийг Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн байна. Улмаар Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн дарга Иво дэ Боероос Монгол Улсын тухайд 2014 оны 7 дугаар сарын 20-оор үүсгэн байгуулах хэлэлцээр хүчин төгөлдөр болсныг мэдэгдсэн

Энэхүү үүсгэн байгуулах хэлэлцээрийн Дархан эрх, эрх ямбын тухай 5 дугаар зүйлд зааснаар Даян дэлхийн ногоон хөгжлийн институт нь төв оффис байрлах гишүүн улсдаа дархан эрх, эрх ямба эдлэх боломжтой, төв оффис нь БНСУ-ын Сөүл хотноо байрладаг бөгөөд бусад гишүүн орнуудын нутаг дэвсгэр дээрх үйл ажиллагаагаа зөв зохистой явуулахад шаардлагатай дархан эрх, эрх ямба эдлэх боломжийг эрэлхийлж болно. Ингэхдээ ижил төстэй олон улсын байгууллагад олгосон дархан эрх, ямбыг харгалзан үзнэ. Дархан эрх, эрх ямбын талаар гишүүдын хооронд эсхүл Даян дэлхийн ногоон хөгжлийн институтаас тухайн гишүүн орсонтой тусдаа гэрээ байгуулж, зохицуулахаар заасан байна.

Иймд тухайн байгууллагад гишүүнээр элссэн нь өөрийн оронд дархан эрх, эрх ямба эдлэх эрхийг заавал олгох үүрэг хүлээсэн зохицуулалт байхгүй болно.

Тус байгууллага нь 2014-2020 онуудад Монгол Улсын Засгийн газартай ногоон хөгжлийн чиглэлээр техник туслалцааны төсөл хэрэгжүүлэх, төслийн судалгаа, санал боловсруулан доноруудад хандаж, санхүүжилт босгох үйл ажиллагаа явуулсан байна. Хэрэгжүүлсэн төслүүдийн хөрөнгө нь Монгол Улсын

нэгдсэн төсөвт тусгагдаж, санхүүжилтийн зарцуулалт, гүйцэтгэл нь хянагддаггүй. Тус байгууллагын ажилтнаас авсан мэдээллээр нийт хэрэгжүүлсэн 3,022,082 ам.долларын төсөл болон төсвийн задаргаа дараах байдалтай байна. / танилцуулгад 7 сая орчим ам.долларын санхүүжилт хийсэн гэсэн боловч үлдсэн хэсэг нь хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн болон бусад үйл ажиллагааны зардалд зарцуулагдсан/.

Чиглэл	Төслийн нэр	Төсөв (ам.доллар)	Хэрэгжүүлсэн он	Хамтран хэрэгжүүлэгч
Бодлогын баримт бичиг	Ногоон хөгжлийн бодлого түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	55,036	2014-2015	БОАЖЯ
	Эрчим хүчний салбарыг ногоон хөгжлийн стратеги 2035	23,000	2015	ЭХЯ
	Эрчим хүчний хэмнэлтийн хууль	42,000	2015	ЭХЯ
	Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	18,000	2016	БОАЖЯ
	ЭХ хэмнэлтийн үндэсний хөтөлбөр боловсруулах	35,000	2017	ЭХЗХ
	Хот байгуулалтын хуульд оруулах нэмэлт өөрчлөлт	35,000	2018	БХБЯ
	Парисын гэрээгээр хүлээсэн Үндэсний хувь нэмрийг тодорхойлох (INDC)	30,000	2019	БОАЖЯ
Техник туслалцаа	Боловсролын ногоон барилгын үнэлгээ	28,000	2015	БОАЖЯ, БХБЯ
	Нийтийн тээврийг ногооруулах стратеги	23,000	2015	ЗТЯ
	Усны нэгдсэн мэдээллийн сан байгуулах	73,500	2016	БОАЖЯ
	Ногоон цэцэрлэгийн зураг төсөл боловсруулах, санхүүгийн механизмын үнэлгээ	91,020	2016-2017	БОАЖЯ, БХБЯ, БСШУЯ, Нийслэлийн боловсролын газар
	Монгол улсын хот суурин газрын төвлөрсөн дулаан хангамжийн нөхцөл байдлын үнэлгээ	47,000	2016	БОАЖЯ, ЭХЯ
	Архангай, Ховд, Булган аймгийн төвийн дулаан хангамжид ногоон технологи нэвтрүүлэх санхүү, технологийн шийдлүүдийг тодорхойлох, чадавх бэхжүүлэх	120,000	2016	БОАЖЯ, ЭХЯ

Барилгын дулаан алдагдлыг тооцох аргачлал	85,000	2016	БОАЖЯ, ЭХЯ
Байгаль орчны салбарын ногоон статистик боловсруулах	18,000	2017	
Загвар ногоон аймгуудын Ногоон хөгжлийн стратегийг боловсруулах (Архангай, Ховд, Булган, Өвөрхангай, Хэнтий)	50,000	2016-2017	БОАЖЯ,
Хог хаягдлаас эрчим хүч үйлдвэрлэх ТЭЗҮ	27,000	2016	БОАЖЯ,
Барилгын ногоон материалын мэдээллийн сан байгуулах	25,000	2017	БХБЯ
Боловсрол ба байгаль орчны салбарын ногоон Төр Хувийн Хэвшлийн Түншлэл	282,000	2017	БХБЯ, БОАЖЯ, БСШУЯ
Ядуурлын эсрэг хүртээмжтэй ногоон хөгжлийн үнэлгээ	28,000	2017	Булган аймгийн ЗДТГ
Эрчим хүчний хэрэглээг шошгожуулах суурь судалгаа	35,000	2018	ЭХЗХ
ХАА-н салбараас ялгарч буй хүлэмжийн хийн тооцох аргачлал, бууруулах боломжийн суурь судалгаа	46,000	2019	БОАЖЯ
Аж үйлдвэрийн н салбараас ялгарч буй хүлэмжийн хийн тооцох аргачлал, бууруулах боломжийн суурь судалгаа	46,000	2019	БОАЖЯ
Парисын гэрээг хэрэгжүүлэхэд Улаанбаатар хотын оруулах хувь нэмрийг тооцоолох	36,000	2018	Нийслэлийн БОАЖГ
Улаанбаатар хотын угсармал орон сууцны дулаан алдагдал, түүний дулаан техникийн шинэчлэлийн бизнес загварыг боловсруулах	30,000	2018	УБ хотын захирагчийн ажлын алба
Угсармал орон сууцны эрчим хүчний аудит	25,220	2018	УБ хотын захирагчийн ажлын алба
Үүрэг хүлээсэн 15 аж ахуйн нэгжүүдийн эрчим хүчний аудит	136,120	2018	ЭХЗХ

	Монголын ногоон санхүүгийн корпорац байгуулах бизнес загвар болон зах зээлийн судалгаа	84,714	2017-2019	УБ хотын захирагчийн ажлын алба
	Угсармал орон сууцны дулаан техникийн шинэчлэлийн суурь судалгаа, бизнес загвар, оршин суугчдын судалгаа, санхүүгийн механизм боловсруулах	508,000	2019-2020	БХБЯ, УБ хотын захирагчийн ажлын алба
	Цэнэг хураагуурын худалдах, худалдан авах гэрээний загварыг боловсруулах	50,000	2019	ЭХЯ, ЭХЗХ, Диспетчерийн үндэсний төв
	Төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй төрийн өмчит сургууль, цэцэрлэгийн дулаан хангамжийн технологийн шийдэл, ТЭЗҮ боловсруулах	53,896	2019	ЭХЗХ
	Тархмал Нарны цахилгаан үүсгүүр хөгжүүлэх чиглэлээр санхүүжилт татах төсөл боловсруулах зорилгоор урьдчилсан ТЭЗҮ	85,000	2020	ЭХЗХ
	Монгол улсад хөдөлгүүр, давтамж хувиргуурын үр ашгийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн үзэл баримтлал боловсруулах	24,884	2020	ЭХЯ
	Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн хууль эрх зүйн орчныг сайжруулах хуулийн зөвлөгөө	24,742	2020	ЭХЯ
	Төрийн өмчит сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилгуудад эрчим хүчний аудит хийх	24,950	2020	ЭХЗХ
	Монгол улсын агаарт богино хугацаагаар оршиж уур амьсгалд нөлөөлдөг хий (Short-lived Climate Pollutants), хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга 2030 он хүртэл тодорхойлох төслийг	50,000	2020-2021	БОАЖЯ
Олон нийтийг гэгээрүүлэх	Тогтвортой хөгжлийн үндэсний форум- 2015 оноос хойш жил бүр	35,000	2015-2019	БОАЖЯ

мэдээлэл, сурталчилгаа	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний форум-2015 оноос хойш жил бүр	35,000	2015-2019	ЭХЯ, СЭХҮА
	Парисын гэрээг хэрэгжүүлэхэд оруулах Үндэсний хувь нэмэр форум	10,000	2019	БОАЖЯ
	Ногоон технологи үндэсний чуулган, үзэсгэлэн худалдаа 2015 оноос хойш жил бүр	120,000	2015-2020	БОАЖЯ
	Эко сургууль цэцэрлэгүүдэд зориулсан ногоон хөгжлийн боловсрол олгох богино видео	13,000	2018-2019	БОАЖЯ, Нийслэлийн Байгаль орчны газар
	Эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөрийг таниулах инфографик болон постерууд	15,000	2019-2020	ЭХЗХ
Чадавх бэхжүүлэх, туршлага судлах	5 аймгийн ХБХ, БОАЖГ-н мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтууд	198,000	2015-2020	БОАЖЯ, ЭХЯ, БХБЯ, УБЗААА, ЭХЗХ
	Дулаан хангамжийн мэргэжилтнүүдийн сургалт			
	ЭХЯ, ЭХЗХ, БХБЯ, МХГ-н албан хаагчдын Хятад улсад хийсэн туршлага судлах 2 удаагийн аялал			
	ЭХЯ, УБЗАА, ЭХЗХ, БХБЯ-ны албан хаагчдын Латви улсад хийсэн туршлага судлах аялал			
	БОАЖЯ, ЭХЗХ-ны удирдлага болон мэргэжилтнүүдийн Өмнөд Солонгост болсон ДДНХИ-н ТУЗ-н хурал, жилийн уулзалт, сургалтад хамрагдаж аялал			
	Монгол улсын агаарт богино хугацаагаар оршиж уур амьсгалд нөлөөлдөг хий (Short-lived Climate Pollutants), хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах тооцооллыг хийх арга зүйн сургалт-Үндэсний түвшний болон бүх			

	аймгуудад нийт 400 гаруй мэргэжилтэн			
	БХБЯ, ЭХЯ, СЯ, ЭХЗХ зэрэг байгууллагуудын мэргэжилтнүүдэд зориулсан Филлипин, Словак улсад хийсэн туршлага судлах аялал			
	НИЙТ ДҮН	3,022,082		

Дараах төслүүдийг хэрэгжүүлэх санал боловсруулж, судалгаа хийх ажлуудыг хийсэн.

Ногоон хөрөнгө оруулалтын чиглэлээр ОУ-н зах зээлээс оруулсан хөрөнгө оруулалт				
Монголын жишиг ногоон цэцэрлэгийн барилга, СХД-н 25-р хороонд АХБ-ны санхүүжилтээр баригдаж байгаа	766,308.98 ам.доллар	2019-2021	БОАЖЯ, БСШУЯ	
Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй Сонгинохайрхан дүүргийн 122 дугаар сургууль дээр газрын гүний насос суурилуулан хосолмол халаалтын технологи нэвтрүүлсэн	257,142 ам. доллар	2020	БОАЖЯ, БСШУЯ Агаар, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо	
Угсармал орон сууцны дулаан техникийн шинэчлэл төслөөр 375 орон сууцыг дахин дулаалах буцалтгүй тусламж- НАМА фасилити	18 сая евро	2020-2023	Энэ нь буцалтгүй тусламж бөгөөд төслийн хэрэгжүүлэгч нь GIZ буюу Германы техникийн хамтын ажиллагааны газар байна. ДДНХИ зөвхөн санхүүжилт босгож өгнө.	

ДИПЛОМАТ ДАРХАН ЭРХ, ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ

Оршил

Монгол Улсад суугаа гадаад улсын ЭСЯ, НҮБ-ын системийн байгууллагын төлөөлөгчийн газар, Ерөнхий консулын газар болон тэдгээрийн ажилтны эрх зүйн байдлыг "Дипломат харилцааны тухай Венийн конвенц", "НҮБ-ын төрөлжсөн байгууллагын дархан эрх, эрх ямбын тухай конвенц", "Консулын харилцааны тухай Венийн конвенц"-оор тус тус зохицуулдаг.

Монгол Улс 1966 онд "Дипломат харилцааны тухай Венийн конвенц"-д, 1970 онд "НҮБ-ын төрөлжсөн байгууллагын дархан эрх, эрх ямбын тухай конвенц"-д, 1988 онд "Консулын харилцааны тухай Венийн конвенц"-д нэгдэн орсон тул эдгээр конвенц нь дотоодын хуулийн адил хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд Монгол Улс дагаж мөрдөх, хэрэгжилтийг нь хангах үүрэгтэй юм.

Дархан эрх, халдашгүй байдал

"Дипломат харилцааны тухай Венийн конвенц"-ын 41 дүгээр зүйлийн 1, мөн "Консулын харилцааны тухай Венийн конвенц"-ын 55 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу:

"Эрх ямба, дархан эрх эдлэгч бүх хүн суугаа улсынхаа хууль, журмыг өөрсдийн эрх ямба, дархан эрхэд хохиролгүйгээр хүндэтгэх (ерөнхий) үүрэгтэй" байдаг.

Ийм онцгой зохицуулалтын үндсэн зорилго нь элчин сайд болон дипломат ажилтныг суугаа орны төр засгийн нөлөөнөөс ангид байлгахад оршихын сацуу нөгөө талаар төрт улс хоорондын харилцаанд үзүүлж буй хүндэтгэлийн нэг илэрхийлэл юм.

"Дипломат харилцааны тухай Венийн конвенц"-ын 31 дүгээр зүйлд зааснаар **аливаа дипломат нь суугаа улсдаа эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх дархан эрхтэй. Тэрчлэн ихэнхи тохиолдолд иргэний болон захиргааны шүүхээс оногдуулах хариуцлагаас чөлөөлөгддөг.**

Дипломат нь, жишээлбэл, гэрчийн хувьд шүүхэд мэдүүлэг өгөх үүрэггүй. Гагцхүү дипломат сайн дураараа буюу өөрөө хүссэн тохиолдолд эсвэл томилогч улс нь зөвшөөрсөн эсвэл дархан эрхийг нь цуцалсан тохиолдолд л суугаа улсын шүүхэд дуудагдах, хариуцлагад татах боломжтой. Суугаа улсын аливаа шүүн таслах ажиллагаанаас чөлөөлөгдөх энэ онцгой эрхийг дипломат дархан эрх (Immunity) гэнэ.

"Дипломат харилцааны тухай Венийн конвенц"-ын 29 дүгээр зүйлийн дагуу **халдашгүй байдал** (Inviolability):

"Дипломат төлөөлөгчийн бие халдашгүй байна. Түүнийг ямар ч хэлбэрээр баривчлах буюу албадан саатуулж үл болно. Хүлээн авагч улс дипломат төлөөлөгчийг зохих ёсоор хүндэтгэж, түүний бие, эрх чөлөө, нэр төрд аливаа ямарваа байдлаар халдахаас урьдчилан сэргийлэх бүхий л зохистой арга хэмжээ авна." гэж заасан.

Иймд УБ хотод суугаа гадаад улсын ЭСЯ, НҮБ-ын төрөлжсөн байгууллагын, түүнтэй адилтгах ОУБ-ын тэргүүн, дипломат ажилтан, гэр бүлийн гишүүд дипломат дархан эрх, халдашгүй байх эрхийг эдэлж манай улсын цагдаа, хууль хяналтын

байгууллага, шүүхээс тэдний энэ дархан эрх, эрх чөлөөнд ямар ч тохиолдолд халдаж болохгүй юм.

Бодит амьдрал дээр гагцхүү тухайн цаг мөчид онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд цагдаа, хууль хяналтын байгууллага нөхцөл байдалд тохируулан түр хугацааны, зөв зохистой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Венийн конвенцыг зөрчсөнд тооцохгүй, жишээлбэл илт согтуу дипломат/гэр бүлийн гишүүн машин жолоодож байвал замын цагдаа хөдөлгөөнд оролцохыг албадан таслан зогсоох (тээврийн хэрэгслийн түлхүүрийг түр хураах), эсвэл хэрэг зөрчлийг үйлдэл дээр нь илрүүлэн дипломатыг/гэр бүлийн гишүүнийг хэрэг бүртгэлийн баримтжуулах ажиллагаанд түр байлцуулан биеийн байцаалт авах, тээврийн осолд оролцсон бол хэргийн газар дээр баримтжуулах ажлын хүрээнд биеийн байцаалт авахаар түр хугаацанд хэргийн газраас явуулахгүй байх зэрэг үйлдлүүд “зөвшөөрөгдөх” магадлалтай.

“Дипломат харилцааны тухай Венийн конвенц”-ын 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу ДТГ-ын тээврийн хэрэгслийг нэгжиж, албадан дайчилж, битүүмжилж, барьцаалж болохгүй гэдгийг цагдаагийн байгууллага мөн анхаарах учиртай.

Мөн “Дипломат харилцааны тухай Венийн конвенц”-ын 28, 33, 34 дүгээр зүйлийн дагуу дипломат нь суугаа орны албан татвар, хураамжаас чөлөөлөгдөх эрх ямба эдэлдэг.

Хэрэг зөрчил үйлдэх тохиолдолд

Дархан эрх, халдашгүй байдлаар хамгаалагдсан дипломатыг/гэр бүлийн гишүүнийг суугаа улсын хууль хяналтын байгууллага хариуцлагад татаж болохгүй гэдэг эрх зүйн үндэслэлийг дээр тайлбарлаж, зарчмын хувьд хуулийн хариуцлага суугаа улс хүлээлгэх боломжгүй гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

Гэхдээ дипломатын хэрэг, зөрчлийг баримтжуулж цагдаа, хууль хяналтын байгууллагаас зохих мэдээллийг ГХЯ-нд тухай бүрт ирүүлж байх нь зүйтэй юм. Хэрэг, зөрчлийн асуудлыг ГХЯ нягталж үзээд зохих шатлалтай арга хэмжээ авч байх учиртай. Тухайлбал,

- Холбогдох ЭСЯ, Олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, ЕКГ-т мэдэгдэх, тайлбар хүсэх буюу шаардах, элчин сайдыг нь дуудаж уулзах, анхааруулах,
- Ноцтой хэрэг, зөрчил байх тохиолдолд холбогдох дипломатын гэм бурууг үнэлж цэгнээд амаар, ноотоор байр суурь илэрхийлэх,
- Суугаа орноос тодорхой хугацааны дотор бүр мөсөн явахыг шаардах,
- “Дипломат харилцааны тухай Венийн конвенц”-ын 9 дүгээр зүйлийн дагуу тааламжгүй этгээд /persona non grata/ гэж албан ёсоор зарлаж суугаа орноос явахыг шаардах явдал юм. Хэрэв томилогч улс нь энэ шаардлагыг биелүүлэхгүй байх тохиолдолд тухайн тааламжгүй этгээдийг ГХЯ “дипломат корпус хамааралгүй болсонд тооцох” шийдвэр гаргаж болно.

Бусад зүйл

Монгол Улсад зорчиж буй гадаадын дипломат паспорт бүхий иргэн бүр дипломат дархан эрх, эрх ямбыг шууд эдлэхгүй.

ГХЯ-ны ДЁГ-аас үнэмлэх авсан дипломат, гэр бүлийн гишүүд нь Венийн конвенцын дагуу дипломат дархан эрх, эрх ямба эдэлнэ.

Тэрчлэн гадаад улсын **төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн, гадаад хэргийн сайд** нарт албан болон хувийн зорилгоор зорчиж байхад нь олон улсын заншлын эрх зүйн дагуу дипломат дархан эрх, эрх ямбыг эдлүүлдэг. Мөн төрийн өндөр, дээд, албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд орсон /уригдсан/ төлөөлөгчдийг айлчлалын хугацаандаа дипломат дархан эрх, эрх ямба эдлэнэ гэж үздэг.

Дархан эрх, халдашгүй байдлыг эдлэх субъектуудын хувьд тухайлбал, дипломат, консул, ЭСЯ-ны захиргаа-техникийн ажилтан, гэрийн ажилтан, гэр бүлийн гишүүд, өргөмжит консул г.м. зэрэглэл, чанарын ялгаа нь “Дипломат харилцааны тухай Венийн конвенц”, “НҮБ-ын төрөлжсөн байгууллагын дархан эрх, эрх ямбын тухай конвенц”, “Консулын харилцааны тухай Венийн конвенц”-д нарийн тусгагдсан байдаг.

Иймд, ДТГ, ЕКГ, Олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт болон бие бүрэлдэхүүнд хүндэтгэлтэй хандаж байхыг дотоодын хууль сахиулах байгууллагуудад тогтмол анхааруулж байх нь зүйтэй юм.

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН ГАЗАР

2021 оны 3-р сарын 26.

“Дипломат харилцааны тухай Венийн конвенц”-ын холбогдох чухал зүйл, заалтыг хавсаргав.

22 дугаар зүйл

1. Төлөөлөгчийн газрын байр халдашгүй байна. Хүлээн авагч улсын эрх мэдэлтэн төлөөлөгчийн газрын тэргүүний зөвшөөрөлгүйгээр тэрхүү байранд орж үл болно.
2. Хүлээн авагч улс төлөөлөгчийн газрын байранд элдвээр халдах буюу хохирол учруулахаас хамгаалах, төлөөлөгчийн газрын амгалан тайван байдлыг элдвээр алдагдуулах буюу түүний нэр төрийг доромжлохоос урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах онцгой үүрэг хүлээнэ.
3. Төлөөлөгчийн газрын байр, тавилга, бусад эд хөрөнгө, түүнчлэн төлөөлөгчийн газрын тээврийн хэрэгслийг нэгжих, албадан дайчлах, битүүмжлэх, шийдвэр гүйцэтгэлээс чөлөөлнө.

25 дугаар зүйл

Хүлээн авагч улс төлөөлөгчийн газарт чиг үүргээ биелүүлэхэд нь бүх боломжийг олгоно.

26 дугаар зүйл

Улсын аюулгүй байдлын үүднээс нэвтрэн орохыг хориглосон буюу тусгай журмаар зохицуулдаг бүсийн тухай хууль, журамд нь харшлахгүй бол төлөөлөгчийн газрын бүх гишүүнийг нутаг дэвсгэрээр нь чөлөөтэй зорчих эрхийг хүлээн авагч улс хангана.

27 дугаар зүйл

1. Хүлээн авагч улс төлөөлөгчийн газрын албаны харилцаа холбоог чөлөөтэй зөвшөөрч, хамгаална. Төлөөлөгчийн газар томилогч улсын засгийн газар, хаана ч байгаа бусад төлөөлөгчийн болон консулын газартай харилцахдаа дипломат элч, түүнчлэн нууц түлхүүртэй буюу шифрлэсэн мэдээ зэрэг зохистой бүх арга хэрэгслийг ашиглаж болно. Гэхдээ төлөөлөгчийн газар радио дамжуулагчийг гагцхүү хүлээн авагч улсын зөвшөөрлөөр суурилуулан ашиглаж болно.
2. Төлөөлөгчийн газрын албан захидал харилцаа халдашгүй байна. Албан захидал харилцаа гэж төлөөлөгчийн газар, түүний чиг үүрэгт хамаарах бүх захидал харилцааг хэлнэ.
3. Дипломат шууданг задалж буюу саатуулж үл болно.

29 дүгээр зүйл

Дипломат төлөөлөгчийн бие халдашгүй байна. Түүнийг ямар ч хэлбэрээр баривчлах буюу албадан саатуулж үл болно. Хүлээн авагч улс дипломат төлөөлөгчийг зохих ёсоор хүндэтгэж, түүний бие, эрх чөлөө, нэр төрд аливаа ямарваа байдлаар халдахаас урьдчилан сэргийлэх бүхий л зохистой арга хэмжээ авна.

30 дугаар зүйл

1. Дипломат төлөөлөгчийн хувийн өргөө төлөөлөгчийн газрын байрны нэгэн адил халдашгүй байна.

2. Дипломат төлөөлөгчийн бүх бичиг баримт, захидал харилцаа, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад өмч хөрөнгө нь нэгэн адил халдашгүй байна.

31 дүгээр зүйл

1. Дипломат төлөөлөгч хүлээн авагч улсын эрүүгийн хэргийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрх эдэлнэ. Мөн дор дурдсанаас бусад тохиолдолд иргэний болон захиргааны хэргийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрхийг эдэлнэ: (а) томилогч улсын өмнөөс төлөөлөгчийн газрын хэрэгцээнд зориулан эзэмшиж байгаагаас бусад хүлээн авагч улсын нутаг дэвсгэр дээр байгаа хувийн үл хөдлөх хөрөнгөд хамаарах эд хөрөнгийн нэхэмжлэл; (b) дипломат төлөөлөгч гэрээсийг биелүүлэгч, өвлөх эд хөрөнгийг харгалзагч, өвлөгч буюу өв залгамжлагчийн үүргийг томилогч улсын өмнөөс биш, хувь хүний тухайд гүйцэтгэж байгаа өвийн холбогдол бүхий нэхэмжлэл; (c) дипломат төлөөлөгчөөс албан үүргийнхээ хүрээнээс гадна хүлээн авагч улсад хэрэгжүүлж байгаа мэргэжлийн буюу арилжааны аливаа үйл ажиллагаатай холбоотой нэхэмжлэл.

2. Дипломат төлөөлөгч нь гэрчийн хувьд мэдүүлэг өгөх үүрэггүй.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн (a), (b), (c) дэд хэсэгт хамаарахаас бусад тохиолдолд дипломат төлөөлөгч хүнд ямарваа гүйцэтгэх ажиллагааны арга хэмжээ авч үл болох бөгөөд арга хэмжээ авч болох тохиолдолд түүний бие буюу өргөөний халдашгүй байдлыг зөрчихгүй байна.

4. Дипломат төлөөлөгч хүлээн авагч улсын шүүхийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрх нь түүнийг томилогч улсын шүүхийн харьяаллаас үл чөлөөлнө.

32 дугаар зүйл

1. Томилогч улс 37 дугаар зүйлийн дагуу дархан эрх эдэлж байгаа өөрийн дипломат төлөөлөгч болон бусад хүний шүүхийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрхээс татгалзаж болно.

2. Татгалзаж байгааг ямагт тодорхой илэрхийлсэн байвал зохино.

3. 37 дугаар зүйлийн дагуу шүүхийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрх эдэлж байгаа дипломат төлөөлөгч буюу бусад хүн нэхэмжлэл гаргах тохиолдолд тухайн үндсэн нэхэмжлэлтэй нь шууд холбоотой ямар нэгэн сөрөг нэхэмжлэл гарвал тэрбээр шүүхийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрхээ алдана.

4. Иргэний болон захиргааны хэргийн талаар шүүхийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрхээс татгалзах нь шийдвэр гүйцэтгэлийн талаар эдлэх дархан эрхээс татгалзаж байгаа хэрэг биш.

37 дугаар зүйл

1. Дипломат төлөөлөгчийн хамт амьдран суугаа гэр бүлийн гишүүд хүлээн авагч улсын иргэн биш бол 29-36 дугаар зүйлд заасан эрх ямба, дархан эрхийг эдэлнэ.

2. Төлөөлөгчийн газрын захиргаа-техникийн бүрэлдэхүүний гишүүд болон тэдэнтэй хамт амьдран суугаа гэр бүлийн гишүүд хүлээн авагч улсын иргэн биш буюу тэнд байнга оршин суудаггүй бол 29-35 дугаар зүйлд заасан эрх ямба, дархан эрхийг эдэлнэ. Гэхдээ 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан иргэний болон захиргааны хэргийн харьяаллаас чөлөөлөгдөх дархан эрх тэдгээр хүмүүсийн албан үүргээ гүйцэтгэхээс гадуур явуулсан үйлдэлд үл хамаарна. Мөн тэдгээр хүмүүс анх төвхнөн

суухад холбогдсон эд юмсын тухайд 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх ямбыг эдэлнэ.

3. Төлөөлөгчийн газрын үйлчлэх бүрэлдэхүүний гишүүд хүлээн авагч улсын иргэн биш буюу тэнд байнга оршин суудаггүй бол албан үүргээ гүйцэтгэх явцад **хийсэн үйлдлийнхээ хувьд дархан эрх эдлэж**, албан ажлынхаа хөлсөнд авсан цалин нь татвар, хураамжаас чөлөөлөгдөхөөс гадна 33 дугаар зүйлд дурдсан чөлөөлөгдөх эрх эдэлнэ.

Агуулга:

-
1. Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Институтын (ДДНХИ)-ын ерөнхий танилцуулга
 2. МУ-ын Засгийн газартай хамтран ажиллаж буй тухай
 3. ДДНХИ-ын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон ололтууд
 4. ДДНХИ болон БОАЖЯ хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичиг болон гишүүн улсын хэлэлцээр
-

1. Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Институт (ДДНХИ)

- Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Институт нь (ДДНХИ) бүрэн эрхэт улс орнуудын гишүүнчлэлтэй засгийн газар хоорондын байгууллага бөгөөд хөгжиж буй болон хурдтай өсч буй орнуудад хүчирхэг, хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийг бэхжүүлэхэд чиглэн ажилладаг. ДДНХИ-ын гишүүн орнууд тухайн улс орондоо хөгжлийн шинэ загварыг бий болгон байгаль орчиндоо ээлтэй, нийгэмдээ хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг буюу ногоон өсөлтийг бий болгоход анхааран ажиллаж байна.
- ДДНХИ нь гишүүн орнууддаа уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүрэг амлалтууд болон Тогтвортой хөгжлийн зорилгууддаа хүрэхэд нь дэмжлэг үзүүлэн ажилладаг бөгөөд дараах 6 үндсэн стратегийн ач холбогдол бүхий үр дүнд нөлөөлөх зорилготой (i) ХХЯ-ыг бууруулах, (ii) Ногоон ажлын байр бий болгох (iii) Тогтвортой үйлчилгээ хүртэх боломжийг нэмэгдүүлэх буюу хямд, цэвэр эрчим хүчний хүртээмж, тогтвортой нийтийн тээвэр, сайжруулсан ариун цэврийн байгууламж, хог хаягдлын менежмент гэх мэт (iv) агаарын чанарыг сайжруулах (v) экосистемийн үйлчилгээний зохистой хангамж (vi) уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зэрэг болно.
- ДДНХИ нь тухайн оронд ажиллаж буй багаараа дамжуулан төрөл бүрийн техникийн туслалцааг төрийн байгууллагуудад үзүүлэхийн сацуу уур амьсгалын дасан зохицох, даван туулах чадвар бүхий төслүүдэд хөрөнгө оруулалт татах замаар үйл ажиллагаагаа явуулж байна. ДДНХИ дараах хоёр чиглэлээр гишүүн болон хамтрагч улс орнууддаа үйлчилдэг: бодлогын зөвлөгөө, нсгоон хөрөнгө оруулалтын төслийн хөгжүүлэлт
- ДДНХИ нь дараах 4 үндсэн чиглэлд түлхүү нэн тэргүүний ач холбогдол өгөн ажиллаж байгаа бөгөөд үйл ажиллагаа явуулж буй гишүүн орнуудын эдийн засагт бодитой хувь нэмэр оруулах салбарууд болно. Эдгээрт: Эрчим хүч, ус, газар ашиглалт, ногоон хотын хөгжил
- ДДНХИ нь засаглалын хувьд хоёр үндсэн нэгжтэй: Зөвлөл болон Ассамблей. Ассамблей нь ДДНХИ-ын хамгийн дээд шатны бүтэц бөгөөд гишүүдээс бүрдэнэ. Хоёр жил тутам зөвлөлдөж хуралддаг. Ассамблей нь Зөвлөлийн гишүүдийг сонгох үүрэгтэй бөгөөд Даргыг томилж үүсгэн байгуулах хэлэлцээрт өөрчлөлт оруулах эсэхийг шийддэг. Мөн ДДНХИ-ын үйл ажиллагааны ерөнхий чиглэлийг зөвлөхөөс гадна нарийн бичгийн дарга нарын газраас ирүүлсэн тайлантай танилцаж стратеги, үйл ажиллагаа, санхүүгийн асуудлуудыг шийдвэрлэх талаар чиглэл өгч ажилладаг. Мөн хамтран ажиллах түншүүд, олон улсын байгууллагуудтай холбох чиглэлээр удирдамж өгнө.
- ДДНХИ-ын Зөвлөл нь гүйцэтгэх үүрэг бүхий нэгж бөгөөд дээд тал нь 17 гишүүнээс бүрддэг. Эдгээрийн 5 нь дэмжигч гишүүн байх бөгөөд Ассамблей сонгодог бол удаах 5 гишүүнийг

оролцогч орнуудаас сонгоно. Зөвлөл мөн 5 гишүүнийг төрийн бус оролцогчдоос сонгоно. Эзэн орон Зөвлөлд байнгын суудалтай байх давуу эрхтэй, Дарга сонгох эрхгүй байдаг. Зөвлөлийн гишүүд 2 жилийн хугацаатай сонгогдоно. Зөвлөл нь Ассамблейн удирдамжаар ДДНХИ-ын үйл ажиллагааг удирдах үүрэгтэй. Жишээ нь Даргыг нэр дэвшүүлэн Ассамблейн хурлаар оруулах, ДДНХИ-ын үйл ажиллагааны стратегийг батлах, жилийн ажлын хөтөлбөр, төсөв, үр дүнг хянах, үнэлэх, санхүүгийн аудитын дүгнэлтүүдийг батлах, Зөвлөх хорооны шинэ гишүүдийг элсүүлэн авах, гишүүн орнуудын үйл ажиллагааны хөтөлбөрийг сонгох шалгуурыг батлах, Зөвлөлийн дэд хороонуудын гишүүдийг баталж авах, Ассамблейн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх гэх мэт.

- 2018 оны 03 дугаар сард НҮБ-ын 8 дахь Ерөнхий нарийн бичгийн дарга асан Др.Бан Ги Мүүн ДДНХИ-ын Ерөнхий Ассамблейн тэргүүн, зөвлөлийн даргаар сонгогдон ажиллаж эхэлсэн. Тэрээр 2018 оны 4 дүгээр улиралд зохион байгуулагдах ДДНХИ-ын 11 дэх удаагийн Зөвлөлийн болон Ассамблейн чуулга уулзалтыг даргалах болно.

2. МУ-ын Засгийн газартай хамтран ажиллаж буй тухай

- 2011 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр ДДНХИ МУ-ын Засгийн газар буюу Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай Хамтран ажиллах санамж бичгийг зурсан. 2014 онд Монгол улс ДДНХИ-г албан ёсоор байгуулах хэлэлцээрийг баталсан билээ. 2019 онд Хамтран ажиллах санамж бичгийг шинэчлэн байгуулсан.
- 2015 оны 10 дугаар сард ДДНХИ-ийн 2016-2020 онд Монгол улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулахад БОАЖЯ дэмжин ажилласан.
- ДДНХИ нь Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад МУ-ын оруулах зорилтот хувь нэмэр, Ногоон хөгжлийн бодлого гэх мэт бодлогын хэрэгжилтүүдийг дэмжин ажилладаг. Үүний тулд манай байгууллага нь салбар яамд, агентлагууд, орон нутгийн засаг захиргаатай нягт уялдан ажиллаж ногоон хөгжлийн бодлогыг үйл ажиллагаанд нь, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд, төсөл хөтөлбөрүүдэд нь тусган ажиллаж байна. Энэ зорилгын үүднээс бид 2017 онд Нийслэл Улаанбаатар хотын захиргаа, Эрчим хүчний зохицуулах хороо, Барилга хот байгуулалтын яамтай Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан билээ.

3. ДДНХИ-ийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд:

- ДДНХИ-ийн 2015-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд дараах гурван чиглэлийг сонгон авч ажилласан. Эдгээр нь: Тогтвортой эрчим хүч, ногоон хотын хөгжил болон ус, ногоон төслүүдийн хөрөнгө оруулалт зэрэг болно.
- ДДНХИ-ийн энэ хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь МУ-ын Засгийн газраас ногоон хөгжлийн чиглэлээр авч буй бодлого арга хэмжээнүүдийг шууд дэмжин ажиллахад чиглэж дараах зорилгуудад чиглэж байгаа болно. (i) 2030 он гэхэд эрчим хүчний алдагдлыг 20 хувиар, 2030 он гэхэд 30 хувиар бууруулах зорилтын хүрээнд эрчим хүчний салбарт эрчим хүчний хэмнэлт гаргах замаар ХХЯ-ыг бууруулах; Нийт суурилагдсан эрчим хүчний эх үүсвэрт сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэх (ii) Барилгын эрчим хүчний алдагдлыг 2020 онд гэхэд 20 хувиар, 2030 он гэхэд 40 хувиар бууруулах (iii) Олон улсын байгаль орчны норм стандартуудыг нэвтрүүлж байгаль орчны үнэлгээний чанарыг сайжруулах замаар бүтээмжийг нэмэгдүүлэх, (iv) Нөөцийн ашиглалт бүтээмжийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж нэгж

бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ялгаруулдаг ХХЯ-ыг бууруулан 2020 он гэхэд дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувийг ногоон хөгжлийг дэмжихэд зарцуулна.

- Өнгөрсөн хугацаанд МУ-ын ЗГ-ын үйл ажиллагааг дэмжин ДДНХИ-ийн хэрэгжүүлсэн гол ач холбогдол бүхий арга хэмжээнүүдээс онцолбол:
 - Бодлогын дэмжлэг үзүүлэх хүрээнд 2017 оны 9 дүгээр сард Эрчим хүчний хэмнэлтийн үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар баталсан ажлыг онцлох хэрэгтэй. Мөн Эрчим хүчний зохицуулах хорооноос Эрчим хүчний хэмнэлтийн стандарт, шошгожуулах журмыг шинээр боловсруулан Эрчим хүчний яаманд хүлээлгэн өгөөд байгаа бөгөөд батлагдан гарахыг хүлээж байна.
 - Ногоон хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр Монголын Ногоон санхүүжилтийн корпорацыг үүсгэн байгуулах санаачилгыг гарган 2017 оны 09 дүгээр сард БОАЖЯ, Сангийн Яам, Монголын Банкны холбоо, ДДНХИ зэрэг байгууллагууд хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Уур амьсгалын ногоон сангийн Бэлтгэл ажлыг хангах дэмжлэгийн хүрээнд ДДНХИ нь тус санхүүгийн корпорацын үйл ажиллагааны голлох салбарууд, зах зээлийг судлах, үнэлэх ажлыг хэрэгжүүлсэн. Эдгээрт эрчим хүчний хэмнэлт, хямд өртөгтэй ногоон амины орон сууц, барилгын дулаалгын болон хог хаягдал, ариун цэврийн байгууламжийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээнүүд орж байна. Дээрх чиглэлүүдэд хэрэгжиж болох төслүүдийн санхүүжилтийг Уур амьсгалын ногоон сангаас Монголын ногоон санхүүжилтийн корпорацад төвлөрүүлэх зорилготой. Энэ хүрээнд бид 2018 оны 3 дугаар сард Уур амьсгалын ногоон санд нийт 27 сая ам.долларын төсөл бичиж илгээсэн нь батлагдаж удахгүй үйл ажиллагаагаа эхэлнэ.
 - Угсармал орон сууцны барилгуудад хийсэн эрчим хүчний аудитын үр дүнд суурилан ДДНХИ нь НАМА байгууллагат Улаанбаатар хот дахь хуучны угсармал 362 барилгыг дулаалах төслийн санал боловсруулсан хүргүүлсэн нь батлагдаж нийт 18 сая еврогийн төслийн иж бүрэн үнэлгээ, судалгаа, баримт бичиг бэлтгэх эхний санхүүжилтийг аваад байна.
 - Эрчим хүчний хэмнэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс ЭХЯ болон ЭХЗХ-той хамтран ажиллаж төрийн өмчит сургууль, цэцэрлэгийн барилгуудад эрчим хүчний аудит хийлээ.
 - Барилгын дулаан алдагдлыг хэрхэн тооцох арга зүйг боловсруулах, сургууль, цэцэрлэгийн эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын зураг төсөл, санхүүжилтийн механизмыг боловсруулах зэрэг ажлуудыг амжилттай хэрэгжүүллээ. Үүний үр дүнд СХД-ийн 25-р хороонд анхны Ногоон цэцэрлэг АХБ-ны санхүүжилтээр баригдаж байна. Мөн төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй хотын захын 122-р сургуулийн халаалтыг газрын гүний дулааны хосолсон технологиор шинэчиллээ.
 - Парисын гэрээг хэрэгжүүлэхэд оруулах Үндэсний хувь нэмрийг шинэчлэн тогтооход БОАЖЯ-д дэмжлэг үзүүлэн ажилласан ба буй "Монгол Улсын хүлэмжийн хий, агаар бохирдуулагч хийн ялгарал, тэдгээрийг бууруулах хувилбаруудад дүн шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх" төслийг хамтраг хэрэгжүүлж байна.

4. ДДНХИ болон БОАЖЯ хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичиг болон гишүүн улсын хэлэлцээр

- ДДНХИ болон БОАЖЯ 2011 оны 11 дүгээр сарын 9-ны өдөр Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан бөгөөд энэхүү санамж бичиг нь 5 жилийн хугацаатай байхаар талуудын санал нэгдсэн байсан. 2019 оны 6 дугаар сард санамж бичгийг шинэчлэн зурсан.
- ДДНХИ-ын гишүүн орны хувьд Монгол улс 2013 оны 6 дугаар сарын 9-ны өдөр гишүүн улсын хэлэлцээрийг дэмжиж нэгдэн орсон бол 2014 оны 5 дугаар сарын 19-нд үүсгэн байгуулах гэрээг баталсан. Монгол улсын Гадаад хэргийн яамны 2014 оны 6 дугаар сарын 20-ны (А/14-873) тоот зөвшөөрлөөр Монгол улсад албан ёсоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн болно. Энэхүү зөвшөөрөл нь үүсгэн байгуулах гэрээний 22-р зүйлд заасан дотоодын хууль эрх зүйн журмууд Монгол улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчлэх шаардлага хангагдсаныг батална.
- Дээр дурдсаныг үндэслэн ДДНХИ нь Монгол улсад хууль зүйн талаас хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын байгууллага мөн бөгөөд Үүсгэн байгуулах хэлэлцээр нь Монгол улсад хууль эрх зүйн хувьд хүчин төгөлдөр тул ДДНХИ нь эрх зүйн чадамж бүхий олон улсын байгууллага мөн болохыг баталж байна.
- Гишүүн улсын хэлэлцээрийн зорилго нь ДДНХИ-ын Монгол улсад явуулах үйл ажиллагаа болон арга хэмжээний тогтолцоог байгуулахын зэрэгцээ ДДНХИ үйл ажиллагаа явуулдаг гишүүн улс орнуудад олон улсын засгийн газар хоорондын байгууллагууд эдлэх тодорхой эрх ямба, дархан эрх, халдашгүй байдал болон бусад өөр хөнгөлөлт, татварын чөлөөлөлт зэргийг ДДНХИ-д олгоход оршино. Эдгээр эрх ямба, дархан эрх, халдашгүй байдал болон хөнгөлөлт, татварын чөлөөлөлт олгохыг хүссэн Гишүүн улсын хэлэлцээрийг ДДНХИ Монгол улстай байгуулж байгаа нь онцгой эсвэл өвөрмөц тохиолдол биш харин олон улсын засгийн газар хооронд байгууллага болон Гишүүн улс орнуудын хооронд байгуулдаг стандарт практик юм.

[illegible]

ДДНХБ нь доорхи чиглэлүүдээр оролцогч талуудтай хамтран ажиллаж байна.			
Монголын нэгдсэн эрх зүйн, хөгжүүлэх агентлаг (2013-2033) Бүтэцгүй	Айгуудын дунд-зондоогийн тусгай эрх зүйн бичлэгийн үндсэн, нэгдсэн төлөвлөгөөний шийдвэр	Улаанбаатар хотод эрх зүйн хөгжүүлэх үйлдвэр ХХ-н хэлтэс, эрх зүйн сургуулиа	Эрх зүйн хэмжээтэй үндсэн элсэлтийн багсруулалт Монголын эрх зүйн хэрэгсэлтийн шашны нөлөөгдэх санхүүгийн сургуулиа

[illegible]

```

graph TD
    A[Үндэсний ногоо сөнүүжилтийн механизм] --> B[Төслийн концепт хөгжүүлэлт]
    A --> C[Бизнес төлөвлөгөө хөгжүүлэлт]
    B --> D["Сонгуулийн салбарын институтийн болов боломжит олон улсын уур амьсгалын сонгуулийн дх үүсвэрийг тодорх урьдчилсан үнэлгээ судалгаа"]
    B --> E[НЭС төслийн концепт боловсруулалт]
    C --> F[Хууль эрх зүйн орчны урьдчилсан судалгаа]
    C --> G[НЭС бизнес төлөвлөгөө ба модел боловсруулалт]
    C --> H[Боломжит хөрөнгө оруулалтын замын зураг боловсруулалт]
    I["Ногоо Уур Амьсгалын Сан (НУАС)-ын бэлэн байдлын хөтөлбөр"] --> J["Сонгогдсон дэд салбаруудын зах зээлийн судалгаа ба бүтээгдээгүй хөгжүүлэлт"]
    I --> K[Сан байгуулах хууль эрх зүйн зөвлөгөө үйчилгээ]
    I --> L[Хөрөнгө оруулалт тогтах, хөрөнгө оруулалтын санал бэлтгэхэд зориулсан зөвлөгөө үйчилгээ]
    M["УХХ нарт чиглэсэн эрчим хүчний хэмжээлтийн төслийн хөгжүүлэлт"] --> N[Сонгогдсон 15 УХХ нарын эрчим хүчний хэмжээлтийн болц төслүүд]
  
```

Үндэсний ногоо сөнүүжилтийн механизм

Төслийн концепт хөгжүүлэлт:

- Сонгуулийн салбарын институтийн болов боломжит олон улсын уур амьсгалын сонгуулийн дх үүсвэрийг тодорх урьдчилсан үнэлгээ судалгаа
- НЭС төслийн концепт боловсруулалт

Бизнес төлөвлөгөө хөгжүүлэлт:

- Хууль эрх зүйн орчны урьдчилсан судалгаа
- НЭС бизнес төлөвлөгөө ба модел боловсруулалт
- Боломжит хөрөнгө оруулалтын замын зураг боловсруулалт

Ногоо Уур Амьсгалын Сан (НУАС)-ын бэлэн байдлын хөтөлбөр:

- Сонгогдсон дэд салбаруудын зах зээлийн судалгаа ба бүтээгдээгүй хөгжүүлэлт
- Сан байгуулах хууль эрх зүйн зөвлөгөө үйчилгээ
- Хөрөнгө оруулалт тогтах, хөрөнгө оруулалтын санал бэлтгэхэд зориулсан зөвлөгөө үйчилгээ

УХХ нарт чиглэсэн эрчим хүчний хэмжээлтийн төслийн хөгжүүлэлт:

- Сонгогдсон 15 УХХ нарын эрчим хүчний хэмжээлтийн болц төслүүд

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬ

75 дугаар зүйл. Хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг Улсын Их Хуралтай урьдчилан зөвшилцөх

75.3. Дараах олон улсын гэрээний тухайд олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг **Төсвийн болон Эдийн засгийн** байнгын хороод тус тусдаа урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ:

75.3.1. гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ;

75.3.2. чөлөөт худалдаа, давхар татвар, **хөрөнгө оруулалттай холбогдсон олон улсын гэрээ.**